



ГОВИ

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ
“НООС НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан

Боловсруулсан:

Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга О.Жаргалмаа

Тогтвортой хөгжлийн ахлах менежер А.Гомбосүрэн

Улаанбаатар хот 2025



АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1 Төслийн хүчин чадал
- 1.2 Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим
- 1.3 Үйлдвэрийн товч танилцуулга
- 1.4 Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц
- 1.5 Төслөөс гарах хог хаягдал

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

- 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- 3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.4 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.6 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- 3.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

5. ДҮГНЭЛТ



1. ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1.1. Товч танилцуулга

Төслийн нэр: Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр

Төсөл “Говь” ХК

хэрэгжүүлэгчийн нэр: Улсын бүртгэлийн дугаар: 9010001061

Хаяг: Регистрийн дугаар: 2076357


Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, үйлдвэрийн гудамж, өөрийн байр

Утас:+976-70105511

Төслийн байршил: Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд тус дүүргийн Засаг даргын 2017 оны 02 сарын 03-ны өдрийн А/55 тоот шийдвэрээр олгогдсон 178013/001 18639309696233 тоот нэгж талбарын дугаар бүхий үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших 49883 м², 178013/0060 18639309770292 тоот нэгж талбарын дугаар бүхий конторын зориулалтаар эзэмших 4467 м² талбайд байрлана.

Хүснэгт 1 Төслийн байршил

№	Өргөрөг			Уртраг		
	1	2	3	4	5	6
1	47	54	12.6	106	52	15.3
2	47	54	10.1	106	52	12.7
3	47	54	9.4	106	52	13.1
4	47	54	4.9	106	52	2.6
5	47	54	8.6	106	52	0.7
6	47	54	9.2	106	52	1.5
7	47	54	14.9	106	51	57.9
8	47	54	18.4	106	52	10.3



Зураг.1 Төслийн талбайн байрлал /google earth/

Хүснэгт 2 Газар эзэмших гэрчилгээ, нэгж талбарын дугаар

Гэрчилгээний дугаар	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ м2	Зориулалт
000012494	1780110092	49844	Үйлдвэрлэл
000012497	1780110089	1043	Үйлчилгээ
000012496	1780110105	3498	Дэлгүүрийн барилга
000012498	1780110091	23169	Үйлдвэрлэл, агуулах
000012492	1780200043	7171	Үйлдвэрлэл, цэцэрлэг
0000019428	1681600410	11824	Үйлдвэрлэл, барилга
2206000848	1780110099	10459	Говь зүүн тал



2206000853	1780110087	1289	Спорт заал
2206000846	1780110094	4464	Худалдаа нийтийн
2206000847	1780110093	1782	үйлчилгээний газар төв цогцодлбор
1419000943	4109052357	40000	Үйлдвэрлэл
1419000613	4109052358	33500	Үйлдвэрлэл

“Говь”ХК-ийн эзэмшил талбайн 2.78 га нь хатуу хучилттай, 0.7 га авто зогсоол, 0.7 га ногоон байгууламж, 4.92 га талбайн нь барилгажсан.

Хүснэгт 3. Эзэмшил газруудын талбайн хэмжээ

№	Зориулалт	Талбайн хэмжээ га
1	Авто зогсоол	0.7
2	Ногоон байгууламж	0.7
3	Хатуу хучилттай талбай	2.78
4	Үйлдвэрийн зориулабарилга	2.42
5	Цайны газар	0.15
6	Дэлгүүр	0.21
7	Үйлчилгээний зориулалтай	0.05
8	Химийн туслах материалын агуулах	0.27
9	Нэхмэлийн үйлдвэр	0.19
10	Түүхий эдийн агуулах	0.2
11	Агуулах	0.15
12	Үйлдвэрийн зориулалтай	0.22
13	Оёмол сүлжмэлийн үл хөдлөх	0.38
14	Нэхмэл агуулах	0.05
15	Харуулын байр	0.13



1.2. Төслийн хүчин чадал

Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч “Говь” үйлдвэр нь 1981 онд Япон улсын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан бөгөөд экологийн цэвэр бүтээгдэхүүн болох Монгол ямааны нарийн микронтой 100%-н цэвэр ноолуураар хамгийн дэвшилтэт техник технологийг ашиглан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг дэлхийн топ 5 үйлдвэрлэгчийн нэг юм. Өнөөдрийн байдлаар Монгол улсын ноолуурын салбарт дотоодын нийт зах зээлийн 50-с дээш хувийг дангаар эзэлж, дэлхийн хувцас загварын хөгжилтэй зэрэгцсэн хэмжээнд хөгжсөн амжилтаар өнөөг хүртэл 41 жил тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа үндэсний томоохон үйлдвэрлэгчдийн нэг юм. “Байгаль орчинд сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах технологи” хэрэглэх бодлогыг баримтлан үйлдвэрийн техник, технологийн горимоо шинэчлэн ажиллаж байна.



Зураг.2 Говь ХК-ийн үйлдвэрийн байр



Говь ХК нь Анхан шатны үйлдвэр, Ээрмэлийн үйлдвэр, Сүлжмэлийн үйлдвэр, Нэхмэлийн үйлдвэр, Оёмолын үйлдвэр гэсэн нийт 5 үйлдвэрийн 2600 гаруй ажилтантай 5 газар, 12 хэлтэс, 30 албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Жилдээ дунджаар 1150 тонн түүхий ноолуур боловсруулах 1050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 640,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэж гадаадын зах зээлд дэлхийн 30 гаруй орны 140-өөд харилцагчиддаа "Монголд үйлдвэрлэв" гэсэн шошготойгоор 100% ноолууран бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бөгөөд дотоодын зах зээлийн 68% хувийг дангаар эзэлдэг. Нийт 9 нэрийн барааны дэлгүүр, 7 гэрээт борлуулагчаараа дамжуулан дотоодын худалдан авагчдадаа бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэдэг.

Мөн “Говь” ХК нь орчин үеийн хувцас загварын чиг хандлагатай хөл нийлүүлэн алхаж, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Италийн болон Европын хувцас загварын нэр хүнд бүхий дизайнеруудтай хамтран ажиллаж олон улсын хувцас загварын компаниудын жишгээр жилдээ хавар, зуны болон намар, өвлийн гэсэн загварын коллекцийг гаргаж байна. Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийх ажлыг 2024 оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд 7-р сарын 2-ны өдөр ГОВЬ брэндийн шинэ өнгө төрхийг танилцуулж, логогоо шинэчилж, анх удаагаа брэндийн бэлгэ тэмдэгтэй болов.



Зураг.3 Говь ХК-ийн лого шинэчлэлт



Хүснэгт 4. Түүхэн замнал

Он	Техник, технологийн шинэчлэлийн түүх
1981	Япон улсын засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт буцалтгүй тусламж олгож, Улаанбаатар хотноо ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр байгуулах тухай хэлэцээр байгуулж Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээнд Говь үйлдвэр үүд хаалгаа нээлээ.
1987-1989	Компьютерийн автомат удирдлага бүхий Япон улсын SET-092 сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав.
1991	Олон улсын стандарт ISO-9000 тэмдэгтийг үе шаттайгаар нэвтрүүлж, олон улсын чанарын цом болон гэрчилгээг Монгол улсаас анх удаа авсан.
1994	Япон улсын Shima Seiki брэндийн компьютерийн удирдлагатай сүлжих машиныг суурилууллаа. ISO 9001 Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, №1 гэрчилгээг гардан авсан.
1995-1996	Монгол улсад анх удаа олон улсын чанарын ISO-9001:2000 тэмдэгтийг нэвтрүүлсэн. Итали улсын технологи тоног төхөөрөмжөөр ээрмэл, нэхмэл, сүлжих үйлдвэрийн өргөтгөлийг хийж, 8.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
1997	Монголд анх удаа ноос ноолууран өргөн хөнжил, ноолууран даавуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх “Говь-2” үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авсан.
1999	Гадаад зах зээлээ өргөжүүлэн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоож, АНУ-ын зах зээлд анх удаа 45,000 ширхэг бүтээгдэхүүн нийлүүлсэн.
2000	Утас будах технологи болон орчин үеийн компьютерийн системд холбогдсон сүлжих машинуудыг суурилуулж, Будах үйлдвэрийн техник, технологидоо олон улсын чанарын ISO-1004 тэмдэгтийг нэвтрүүлсэн.
2004	Герман улсын Stoll үйлдвэрийн компьютерийн удирдлага бүхий сүлжих машинаар өргөтгөл хийсэн.
2007	“Говь” үйлдвэрийн төрийн мэдлийн хувьцааг Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар “ЭФ СИ АЙ” ХХК худалдан авсан.



2008	<p>Говь үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн барилгын дизайныг Японы алдарт архитекторч Сайко Кейчиро шинээр хийж, дэлгүүр зургадугаар сард нээлтээ хийсэн.</p> <p>Япон улсын Shima Seiki брэндийн өндөр хүчин чадал бүхий компьютерийн бүрэн удирдлагатай сүлжих SSG122SV маркийн машин, ээрэхийн үйлдвэрт Итали улсын Stalam болон 66-DD 14G Conti Complett брэндийн машинуудыг суурилуулан үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөтгөсөн.</p>
2009	<p>Японы Токио хотод өөрийн салбар дэлгүүрээ нээсэн.</p> <p>Италийн “VVA Consulting Company”-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.</p> <p>Говь Үйлдвэрт техник, технологийн шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийж, Итали, Япон, Швейцарийн тоног, төхөөрөмжүүд суурьлуулсан.</p>
2010	<p>Монголын ноолуурын салбарт анх удаагаа Принт технологийг нэвтрүүлэн, ноолуур дээр зургийг барлан буулгадаг технологитой болсон.</p>
2011	<p>Тоног төхөөрөмжийн шинэтгэл, өргөтгөлд зориулж 7,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>Монгол улсад 6 нэрийн барааны дэлгүүрийг шинээр нээв</p> <p>Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэн, шинээр 300-аад ажлын байрыг зарласан.</p>
2012	<p>Монгол ямааны ноолуурын үндсэн дөрвөн өнгийг цайруулж, будахгүйгээр байгалийн өнгөөр нь бэлэн бүтээгдэхүүн болгох Gobi-Mongolian Organic Cashmere брэндийг худалдаанд гаргаж, Gobi by Saverio Palatella 2012 оны Намар, Өвлийн 100% ноолууран шинэ коллекци гаргасан.</p>
2013	<p>Сүлжих болон болон хялгас ялгах, самнах технологийг шинэчлэн, үйлдвэрлэлийн хэмжээнд нийт 5,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>Сүлжмэлийн машины шинэ технологи болох Whole Garment буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүн сүлжих машинуудыг суурилуулсан.</p> <p>Gobi-Mongolian Organic Cashmere болон Хямдралын дэлгүүрийг шинээр нээсэн..</p> <p>IFF-JFF БОЛОН Panorama, Фестиваль моды, Import Goods Fair зэрэг Япон, Герман, ОХУ, Солонгос, Хятад зэрэг улсуудад зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд амжилтай оролцсон.</p>



	Европын сонгомол хээтэй Баракко загварын драпан оёмол бүтээгдэхүүнийг 5 төрлөөр үйлдвэрлэж, Шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан.
2014	Бельгийн Брюссель болон Швейцарийн Женев хотод салбар дэлгүүрээ нээснээр, гадаад зах зээлд нийт 47 салбар дэлгүүртэй болсон. Будах үйлдвэрийг бүрэн автоматжуулж, ээрмэл утасны агуулахыг 2 дахин өргөтгөж, 50тн-ийн багтаамжтай болгосон.. Нэхмэл болон принтэт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлсэн. Монголд анх удаа хамгийн нарийн утсаар ваксдаж нэхдэг технологийг нэвтрүүлэв Сочи -2014 өвлийн олимпод оролцох баг тамирчдыг ивээн тэтгэсэн.
2015	Пальто, пиджакны үлгэр суулт, оёдлын болон материалын чанарыг цоо шинэ технологийн дэвшилд хүргэх зорилгоор Японы Lapine компанитай хамтран хамтран ажиллаж байна.
2016	Тансаг зэрэглэлийн YAMA брэндийг зах зээлд нэвтрүүлсэн.
2017	2017 оноос эхлэн Хятадын шинэ загварын самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, чанарын үл тохирлыг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ онд нэмэлтээр 5 шугам суурилуулсан.
2018	6 сарын 15-нд Төв аймгийн Сэргэлэн сумын 14.7 га газар шинээр барихаар төлөвлөж буй Анхан шатны цогц үйлдвэрийн шав тавих ёслолыг амжилттай зохион байгуулав. Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр утасны даацыг сайжруулахаас гадна бүтээгдэхүүнд бөөсрөлт үүсгэхгүй байх зэрэг эерэг үр дүнтэй. Цаашид Muratec шилжүүлэн ороох машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэх машинаар ээрнэ. 2018 онд ноолууран пиджакны борлуулалтаар дэлхийд тэргүүлэх зорилгын хүрээнд эмэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан ХБНГУ-ын Indupress тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн. Цаашид эрэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан Malkan тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн масс үйлдвэрлэлийг эхлүүлнэ.



	Японы SHIMA SEIKI MACH2XS оёдолгүй сүлжих 6 ширхэг машиныг шинээр ашиглалтад оруулсан. Энэхүү машин нь бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжиж гаргахаас гадна цамцны захыг өөрөөсөө сүлжиж гаргах онцлогтой юм.
2019	МУ-ын ноолуурын салбарын томоохон бренд үйлдвэрлэгч “Гоёо” ХХК-ийг Дэлхийд танигдсан Монгол брэнд уриан дор “Говь” ХК-тай нэгтгэн авч, салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ. 2019 онд пиджак, өмд үйлдвэрлэхэд зориулсан Malkan фирмийн төрөл бүрийн зориулалттай хэлбэржүүлэх пресс тоног төхөөрөмжийг суурилуулсанаар дэлхийн жишигт нийцсэн эрэгтэй эмэгтэй хослол үйлдвэрлэж байна.
2021	Ээрмэлийн үйлдвэрийн самнах машин тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Италийн Autefa solutions фирмийн октир самнах 4 шугам авч суурилуулж байна. Ашиглалтанд оруулсанаар сүлжмэл бүтээгдэхүүний ноолууран утасыг чанарын өндөр төвшинд үйлдвэрлэж филлинг багасгах ач холбогдолтой.
2022	Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн баталгаажуулалтад Олон улсын стандартын SGS байгууллагаар аудитлагдан амжилттай гэрчилгээ гардан авлаа.
2023	Усны зохистой хэрэглээг нэвтрүүлэгч шилдэг байгууллагаар шалгарлаа. ГОВЬ ХК-н хэрэгжүүлдэг 3 талт төсөл тогтвортой хөгжлийн шилдэг төслөөр шалгарав.
2024	Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн баталгаажуулалтад Олон улсын стандартын SGS байгууллагаар магадлан аудитлагдан амжилттай гэрчилгээ гардан авлаа.
2024	Байгаль орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах, Монгол улсын хууль стандартад нийцсэн дэвшилтэд тоног төхөөрөмжтэй Үйлдвэрээс гарч буй хаягдал ус цэвэрлэх байгууламж шинэчлэн барих төслийг хэрэгжүүлж эхлэв.
2025	Манай байгууллага 2025 онд өөрийн хөрөнгөөр байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт цэвэрлэх технологи бүхий үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж байгуулан ашиглалтад оруулснаар усыг дахин ашиглах, усны нөөцийг хэмнэх бодит боломж бүрдүүлж, байгаль орчинд



	үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах томоохон ололт амжилтыг хэрэгжүүллээ.
--	--

1.3 Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим

Үйлдвэрлэлийн технологи нь ангилан ялгах, угаах, хялгас ялгах, самнах, будах, холих, ээрэх, шилжүүлэн ороох, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах лабораторийн хяналт савлах зэрэг шат дамжлагуудтай юм. Эдүгээ 40 гаруй жил тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаагийн гол үндэс нь дэлхийн зэрэглэлийн хамгийн сүүлийн үеийн техник, технологийг тасралтгүй шинэчлэн, нэвтрүүлсээр байна.

АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭР

Ангилан ялгах алба

1981 онд анхан шатны үйлдвэрийн харьяа “Гар ялгах” цех нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлснээс хойш үйлдвэрлэлийн гол түүхий эд болох ямааны ноолуур дахь хялгас бусад хольц нэр төрлөөр нь мэдрэхүйн гар аргаар технологийн дагуу ангилан ялгалтыг хийдэг. Ямааны ноолуурыг байгалийн үндсэн 4 өнгөөр ялгадаг. Үүнд: 1-р өнгө буюу цагаан ямааны ноолуур, 2-р өнгө буюу улаан ямааны ноолуур, 3-р өнгө буюу хөх ямааны ноолуур энэ өнгө дэлхийн аль ч улсад байдаггүй зөвхөн “Говь” ХК-д ангилан ялгадаг маш ховор тансаг түүхий эд юм. Мөн 4-р өнгө энэ нь хар ямааны ноолуур юм. Ноолуурыг байгалийн 4 өнгөөр ялгахад гадна байгалийн үндсэн 4 өнгөтэй байдгаараа бусад улсынхаас онцлог. Жилдээ 1000 гаруй тн ноолуур, 20-30 тн сарлагийн хөөвөр ангилан ялгах хүчин чадалтай.



Зураг.4 Ноолуур жинлэх болон ангилан, ялгах хэсэг



Угаах алба

Япон улсын Futaba компанийн угаах машинаар угаадаг. Угаах машин нь сэгсрэх, сэмлэх угаах онгоц, туслах онгоц, шахах гол хатаах хэсгээс бүрддэг цагт 350-450 кг ноолуур угаах хүчин чадалтай. Ангилан ялгагдсан бохирноолуурыг Япон улсад үйлдвэрлэгдсэн байгалийн гаралтай моноген, нойген мөн Итали улсад үйлдвэрлэгдсэн теридол савангаар угааж нарийн тоос, шороо, хог, өтөг бууц тослог зунгаг зэргээс салгаж дараагийн дамжлагад технологийн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлдэг. Хаг, их хагтай нэр төрлийн угаасан ноолууран дээрээ хаг хогийг унагаах зорилгоор хаг унагаагч бодис цацдаг.



Зураг.5 Угаах машин

Хялгас ялгах алба

Япон улсын TORIGOE пүүсийн хялгас ялгах 5 ком машинаар угаасан ноолуурын байгалийн хогт хольц, хялгасыг ялгаж самнасан ноолуур гаргах зорилготой. 2015 онд хятад улсад үйлдвэрлэгдсэн самнах машины толгой суурилуулсанаар бүтээгдэхүүний чанар илүү сайжирсан. Жилд 578 тн самнасан ноолуур гаргах хүчин чадалтай үйлдвэрлэлийн технологи нь маш нарийн орчны чийг температурыг тодорхой төвшинд барьж холиог зөв оновчтой тохируулах, машин тоног төхөөрөмжийн тохиргоо, машин баригчийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж стандартад нийцсэн байгалийн ширхэгтийг гэмтээхгүйгээр 100%-н самнасан ноолуур үйлдвэрлэн гаргадаг онцлогтой.

2017 оноос эхлэн Хятадын DONGJIA үйлдвэрийн LFN186A самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим



хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, том үс, хаг хогны хэмжээг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ 2023 онд нэмэлтээр 11 шугам суурилуулсан.



Зураг.6 Самнах, хялгас ялгах машин

Баглах нэгж

Япон улсад үйлдвэрлэгдсэн HAN-EI маркийн баглах машинаар баглаа хийдэг. 1цагт 250 кг ноолуур баглах хүчин чадалтай. Хялгас ялгах 1,2-р албанаас ирсэн 80%-ийн ноолуурыг нэг төрөл, бэлтгэн нийлүүлэгч болон тухайн түүхий эдийг угаасан савангийн нэр төрлөөр нь зориулалтын бор таар, бор цаас, туузан төмөр, түгжээ төмөр, төмөр утас ашиглан баглааг 70 кг жингээс хэтрүүлэхгүй баглана. Хялгас ялгах 1,2-р албаны хялгас, богино ноолуур, холио, тунелийн хог болон бусд албанаас ирсэн хаягдлуудыг багладаг.

ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Самнасан ноолуурыг будах, цайруулах, цайруулж будах, Гогцоо утас будах, ороох, хатаах гэсэн технологи ажилбараар үйлдвэрлэлээ явуулдаг. Жилд 800-900тн задгай ноолуур будаж, цайруулах, цайруулж будах хүчин чадалтай. Итали улсын STALAM фирмийн радио долгионы хатаах машинаар, ширхэгтийг гэмтээхгүйгээр будсан ноолуур болон утсаа хатаадаг. Итали улсын Loris Bellini пүүсийн бүрэн автомат компьютерийн удирдлагатай будах чихэх, сэгсрэх, сугалах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон будахын машинтай. Өнгөний болон шинжилгээний өвч тоноглогдсон 2 лабораторитой. Гадаад, дотоодын хэрэглэгч захиалагчдын хүссэн өнгийг гаргаж, эрэлт хэрэгцээг нь хангаж



ажилладаг. Одоо 1900 гаруй өнгөтэй. АНУ-ын Datacolor-800 аппаратаар эх загвартай нь өнгөний зөрүүг уншуулж баталгаажуулдаг.

Лабораторит чанарын 9 үзүүлэлтээр шинжилгээ дүгнэлт гаргаж ажилладаг. Үйлдвэрийн дамжлагад Англи, Швейцарь улсаас 90 гаруй төрлийн химийн бодис нийлүүлэгдэн ашиглагдаж байгаль орчин болон хүний биед сөрөг нөлөөлөлгүй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг.



Зураг.7 Будах алба

Ээрэх алба

Сүлжих, оёх нэхэх дамжлагуудыг ээрмэл утсаар хангадаг. Жилдээ 1300тн сайн чанарын 100 хувийн ноолууран нэхмэлийн зориулалттай 14,5/1 16/1 номер, сүлжмэлийн 26/2, 24/1 номерын утас үйлдвэрлэх хүчин чадалтай. Холих, самнах, ээрэх, шилжүүлэн ороох, давхарлан ороох, эрчлэх гэсэн 6 үндсэн дамжлагатай. Ээрмэлийн 1,2-р үйлдвэртэй бөгөөд тоног төхөөрөмж нь сүүлийн үеийн компьютерийн удирдлагатай Итали, Японы мөлхөө ээрэх, шилжүүлэн ороох, давхарлах, эрчлэх машинуудтай. Цувимал болон утасны чанарыг туушийн хэлбэлзэл, номер, даац, суналт, эрч, чийг, пиллинг зэрэг үзүүлэлтүүдээр шалгадаг утасны 2 лаборатори, пиллингийн 1 лабораторитай. Ээрмэл утасныхаа үзүүлэлтүүдийг дээшлүүлэх дэвшилтэд мөлхөө ээрэх технологийг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөлхөө ээрэх нь цахилгааны хэмнэлттэй байгальд ээлтэй тоног төхөөрөмж юм. Олон төрлийн холио хийх хүчин чадалтай 3 холих машинтай. Мөн Италийн Autefa, Overhaul самнах машин суурилуулж чанар бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.



Зураг.8 Ээрэх алба

Нарийн ээрэх алба

Компанийн нэхмэлийн зориулалттай ээрмэл утасны үйлдвэрлэл нь Италийн болон Японы өндөр үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй технологид суурилсан 18 дамжлагатайгаар явагддаг. Үйлдвэр нь жилдээ 30 тонн хүртэл Nm 48/2, Nm 60/2 зэрэг өндөр нарийвчлал шаардсан утас үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд үйлдвэрлэлийн бүх үе шат байгаль орчны менежментийн тогтолцоонд нийцүүлэн зохион байгуулагддаг.

Үйлдвэрлэлийн процессийг холих, самнах, зүүт самнах, нарийн зүүт самнах, сунгах, ээрэх, шилжүүлэн ороох, давхарлан ороох, эрчлэх зэрэг шатуудаар дамжуулан боловсруулдаг ба эдгээр тоног төхөөрөмж нь ресурсийн хэмнэлт, хаягдал бууруулах болон химийн бодисын аюулгүй хэрэглээ зэрэг олон улсын ISO 14001 стандартын зарчмуудыг хангаж ажилладаг. Ээрмэлийн чанарын хяналтыг тусгай зориулалтын лаборатори гүйцэтгэдэг бөгөөд туушийн хэлбэлзэл, номер, даац, суналт, эрч зэрэг гол үзүүлэлтээр тогтмол шинжилгээ хийж, үйлдвэрлэлийн түүхий эдийн зохистой хэрэглээг хангах, буцаалт болон дахин боловсруулалтын хэмжээг бууруулах ач холбогдолтой. Ингэснээр материалын үр ашиг дээшилж, үйлдвэрлэлийн ул мөр буюу байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл багасдаг. Монгол Улсад анх удаа 100% ноолууран Nm 48–60 номерийн нарийн ээрмэл утас үйлдвэрлэх технологийг нутагшуулсан нь дотоодын нэхмэлийн салбарт инноватив ахиц төдийгүй байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, тээвэрлэлтийн улмаас үүсэх нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах чухал үр нөлөөтэй. Дотооддоо нарийн утас үйлдвэрлэх боломж бүрдсэнээр импортын хамаарал буурч, байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлд




чиглэсэн хөгжлийн зорилтыг хангаж ажиллаж байна.Цаашид үйлдвэрлэлийн үе шат бүрт эрчим хүч, ус, түүхий эдийн зарцуулалтыг бууруулах, хаягдал материалыг дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн үр ашгийг сайжруулах зэрэг байгаль орчны менежментийн тасралтгүй сайжруулалтын бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.

СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭР



Зураг.9 Сүлжих алба

Сүлжмэлийн зориулалттай ээрмэл утсаар Япон, Итали , Герман, улсын компьютер удирдлагатай бүрэн автомат сүлжих машинаар ажилбар бүрийг чанарын стандарт шаардлагад нийцүүлэн, технологийн 20 гаруй дамжлагаар, аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үндсэн Сүлжих, Оёх, Гүйцэтгэн боловсруулах, Гүйцэтгэх гэсэн дамжлагуудтай. Сүлжмэлийн үйлдвэр нь жилд 1,600,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Европын холбооны улсууд болон Япон, Америк, Канад, зэрэг орнуудад 30 гаруй хувийг экспортолдог. 2024 онд Монгол улсад Хөнгөн аж үйлдвэрийн салбарт анхны конверын системг нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн. Сүлжмэлийн үйлдвэр нь 490 гаруй ажилтантай.



Зураг.10 Оёх алба



НЭХМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Принтийн алба

Принтийн албанд Япон улсын Shima Seiki компанийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжийг суурилуулж, ноолууран бүтээгдэхүүн дээр өндөр нягтралтай дүрс буулгах технологийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү машин нь найман өнгийн тусгай будгийн системтэй бөгөөд өнгөний хязгааргүй сонголттой, хэрэглэгчийн хүссэн бүх төрлийн зураг, хээ, дизайныг нарийвчлалтайгаар ноолууран бүтээгдэхүүн дээр хэвлэх боломжийг бүрдүүлдэг.

Технологийн онцлог нь:

- Өндөр нарийвчлалтай хэвлэлтээр бүтээгдэхүүний чанар, өнгөний тогтвортой байдлыг сайжруулах
- Захиалагчийн хүсэлтэд тулгуурлан хувийн хэрэглээнд зориулагдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Хурдан, алдагдал багатай үйлдвэрлэлийн горимыг бүрдүүлэх

Принтийн технологи нь уламжлалт будгийн аргаас ялгаатайгаар усны зарцуулалт бага, химийн бодисын хэрэглээг бууруулсан, хаягдал бараа багатай зэрэг олон давуу талтай. Энэ нь байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн нэгэн чухал шийдэл бөгөөд компанийн ногоон үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдаж байна. Мөн тус дамжлага нь ISO 14001:2015 стандартын хүрээнд химийн бодисын зөв хэрэглээ, хадгалалт, хяналт, хаягдлын зохистой менежментийг ханган ажилладаг бөгөөд орчны нөлөөллийг бууруулах, байгальд ээлтэй технологийг ашиглах зарчмыг хэрэгжүүлснээр компанийн тогтвортой үйлдвэрлэлийн зорилтыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.



Зураг.11 Принтийн алба



Нэхэх алба

нэхмэлийн үйлдвэрлэл нь Япон, Итали, Герман, Хятад, Финланд, Швед зэрэг өндөр хөгжсөн орнуудад үйлдвэрлэгдсэн технологийн дэвшилтэй 23 төрлийн машин, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Үйлдвэрлэлийн шугамд угаах, сэгсрэх, жигнэх, хатаах, үслэх, хяргах, сойздох, цацаг эрчлэх, агшаах, өргөн үслэх, боргоцой үслэх, пресс индүү хийх, оёдол, гар нэхэх, шалгах зэрэг бүх үндсэн шат дамжлагууд багтсан бөгөөд эдгээр нь үйлдвэрлэлийн чанарыг тогтвортой хадгалах, материалын алдагдлыг бууруулах боломжийг бүрдүүлдэг.

Эдгээр технологиуд нь:

- Эрчим хүчний үр ашигтай ажиллагаатай
- Усны хэрэглээг бууруулсан
- Хаягдлын хэмжээг багасгах шийдлүүдтэй
- Химийн бодисын аюулгүй хэрэглээ, хяналттай

Үйлдвэр нь жилдээ 63,000–103,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай бөгөөд үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ISO 14001:2015 стандартад нийцсэн байгаль орчны менежментийн тогтолцоог мөрдөж, нөөцийн үр ашигтай хэрэглээ болон бохирдлоос хамгаалах бодлогыг хэрэгжүүлдэг. Бүтээгдэхүүнийхээ 70 орчим хувийг дэлхийн 30 гаруй улс оронд экспортолдог ба олон улсын зах зээлд нийлүүлэлт хийхдээ хаягдал бууруулах, тогтвортой эх үүсвэрийн түүхий эд ашиглах, цахилгаан эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх зэрэг байгаль орчинд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг.12 Нэхмэлийн алба



ОЁМОЛЫН ҮЙЛДВЭР

Оёмолын үйлдвэр нь 1996 оны 3 сарын 8нд “Зөөлөн оёдлын цех” нэртэйгээр 5 хүнтэй байгуулагдсан. Говь ХК-н ажилчдын хувцас хөнжил, хүүхдийн бойтог, нуруувч, майк зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.

2013-2017 онуудад масс үйлдвэрлэлд ашиглагдах бүх төрлийн шулуун оёдол болон тусгай зариулалтын Япон, Хятад, Италья машинуудыг суурилуулж 100% ноолууран даавуу, драпаар төрөл бүрийн оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэн анх удаа дамжлагын системийг нэвтрүүлэн нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх цаг хугацааг хэмнэж, ажлын бүтээмж нэмэгдэн пальто дээл хүрэм, хантааз, өмд, юбка зэрэг олон төрлийн оёмол бүтээгдэхүүн дамжлагаар үйлдвэрлэж эхэлсэн.

2018 оноос пиджак үйлдвэрлэлийн дамжлагын шугамыг орчин үеийн дэвшилтэт технологиор шинэчилж, Турк улсын “Малкан”, Герман улсын “Индүпресс” компаниудын эрэгтэй, эмэгтэй пиджакны хэлбэржүүлэгч пресс индүүг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн юм. Ингэснээр дэлхийн стандартад нийцсэн төгс чанарын хослол болон пиджакийг үйлдвэрлэж эхэлсэн.

Одоо Оёмолын үйлдвэр нь бүх нэр төрлийн Оёмол бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг бөгөөд 106 ажилтантайгаар үйл ажилагаагаа явуулж сард 2,500 ширхэг, жилд 30,000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай ажиллаж байна. Мөн оёмолын үйлдвэр нь хоёрдогч түүхий эд болох дахин задалсан үзүүрээр хөнжил, аяны хөнжил зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн сард 300 ширхэг, жилд 3600-4000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг.13 Оёмолын үйлдвэр



Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба

“Говь” ХК-ийн Хими цэвэрлэгээ, нөхөн засварын алба нь 1999 онд “Хими цэвэрлэгээ, нөхөн засах цех” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд анх нэг ахлах мастер, гурван нөхөн засагчтай нийт дөрвөн ажилтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байв. Анхны жилүүдэд зөвхөн нөхөн засвар, нойтон угаалга, бүтээгдэхүүний гадаргуугийн шаариг түүж цэвэрлэх зэрэг анхан шатны үйлчилгээ үзүүлдэг байсан бол өнөөдөр цар хүрээгээ өргөжүүлэн, үйл ажиллагааны зохион байгуулалт эрс сайжирчээ. Одоогийн байдлаар Хими цэвэрлэгээ, нөхөн засварын алба нь 3 хүлээн авах цэгээр дамжуулан бүтээгдэхүүн хүлээн авч, нийт 43 хүний ажлын байр бүрдүүлсэн, бүтэц зохион байгуулалт сайтай нэгж болон өргөжсөн. Албаны үндсэн чиг үүрэг нь сүлжмэл болон нэхмэл бүх төрлийн бүтээгдэхүүнд хуурай болон нойтон цэвэрлэгээ хийх, бүтээгдэхүүний ҮНЭ ЦЭНИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг.



Зураг.14 Хими цэвэрлэгээ нөхөн засварын алба



ЧАНАР СТАНДАРТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс нь дотоод хяналтын албаны дарга нар, дотоод хяналтын лаборант, шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр бүх төрлийн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд чанарын хөндлөнгийн давхар хяналт хийх, чанарын хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, чанартай холбоотой хэрэглэгчийн гомдол судлах, шийдвэрлэх, бүтээгдэхүүний чанартай холбоотой гэрчилгээнүүдийн хугацааг сунгах, шинээр бүтээгдэхүүн хөгжүүлэхэд чанарын хяналт тавих, автоматжуулалтын төслүүдэд оролцох зэргээр ажилладаг.

MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу Сорилтын лабораториуд нь шинжилгээг Япон, Швейцарь улсын орчин үеийн компьютерт тоног төхөөрөмжөөр тоноглон бөгөөд Монгол улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдсан ур чадварын сорилтонд 6 төрлөөр амжилттай оролцож гэрчилгээ авсан. Мөн түүнчлэн Герман улсын DRRR (Лаборатори хоорондын туршилт сорилтын лавлагаа төв)-өөс зохион байгуулагддаг ОЛОН УЛСЫН УР ЧАДВАРЫН СОРИЛ ШАЛГАЛТАНД MARTINDALE төхөөрөмжөөр ISO 12947-2 стандартын дагуу Говь ХК-ийн дотоод хяналтын лаборатори анх удаа оролцож чанарын өндөр түвшинд, мэргэжлийн ур чадвараа харуулан амжилттай гүйцэтгэж хангалттай сайн үнэлэгдэж ГЭРЧИЛГЭЭ авсан. Цаашлаад лабораторийн чадавхи, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж олон улсын түвшин хүргэхээр зорьж ажиллаж байна.



Зураг.15 Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс



ТЕХНИКИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Техникийн удирдлагын хэлтэс нь 11 нарийн мэргэжлийн механик инженерүүдээр удирдуулсан 45 гаруй засварчид ажилладаг. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөл бололцоог ханган их засвар урсгал засварыг хийж гүйцэтгэдэг.



Зураг.16 Техник удирдлагын хэлтэс

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС


Говь ХК нь тогтвортой хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн хэлтсийг байгуулан, үйл ажиллагаагаа олон улсын жишигт нийцүүлэхээр зорин ажиллаж байна. Тогтвортой хөгжлийн хэлтэс нь 4 хүний бүрэлхүүнтэйгээр нийгэм, эдийн засаг, байгаль орчны гэсэн үндсэн 3 тулгуур үзүүлэлтүүдийг ханган байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэн ажилладаг:

- Байгаль орчныг хамгаалах: Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хэмнэлттэй, ээлтэй технологийг нэвтрүүлэх.
- Эдийн засгийн үр ашигтай ажиллагаа: Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Нийгмийн хариуцлага: Нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах.

Манай байгууллага нь нөөцийг зохистой ашиглах, тогтвортой үйлдвэрлэлийн соёлыг төлөвшүүлэхээр ажиллаж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах үүднээс 2019 оны 4-р сард ISO 14001:2015 стандартыг нэвтрүүлж, 2022 онд олон улсын SGS байгууллагаас Байгаль орчны менежментийн тогтолцооны гэрчилгээг



хүлээн авч 2023,2024 онуудад магадлан аудитад орж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан. Тогтвортой хөгжлийн хэлтэс нь дотоодын болон олон улсын нэр хүнд бүхий байгууллага, нэгжүүдтэй хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн харилцан туршлага солилцон, тасралтгүй суралцсаар байна. 2023 онд Азийн хөгжлийн банктай хамтран тус байгууллагын санхүүжилтээр Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан цохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.



Зураг.17 Тогтвортой хөгжлийн хэлтсийн бүтэц



“ГОВЬ” ХК-ИЙН “НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР”-ИЙН
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Хөдөлмөрийн дотоод журмын 2.5.3 дахь хэсгийг үндэслэн **ТУШААХ НЬ:**


1. Компанийн 2024 оны бүтэц зохион байгуулалтыг Хавсралт №1-.....-д заасны дагуу шинэчлэн баталж, 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Ц.Оргилболд, Б.Ариунаа/, Дижайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал /Б.Болормаа/-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны А/01 тоот, Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 дугаар сарын 27-ны А/221 тоот, тушаалын энэхүү хавсралтад заасан холбогдох бүтэц зохион байгуулалтыг хүчингүйд тооцугай.
3. Шинээр батлагдсан бүтэц, орон тосны дагуу үйл ажиллагаа, хүн хүчээ хэвийн зохион байгуулан тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд захирал /Ц.Оргилболд, Б.Ариунаа/, Дижайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал /Б.Болормаа/, Хүний нөөцийн газар /Д.Соёлмаа/-г тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.АМАРСАЙХАН

20243921



Зураг.19 Говь ХК-ийн план



1.4. Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц

Тоног төхөөрөмж: “Говь” ХК-ийн тоног төхөөрөмжийн 65% нь Итали, Герман, Швейцар, Японых, 35% нь Хятад Тайваных байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийн хэлтэс албуудад техник, технологийн шинэчлэл байнга хийж үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлсээр ирсэн бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 1155 төрлийн тоног төхөөрөмж шинээр суурилуулсан. Нийт 1735 тоног төхөөрөмжтэй

Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:

Төвийн эрчим хүч, дулаанд холбогдсон. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК болон “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-тай гэрээ байгуулсан.

Усан хангамж:

Төвлөрсөн шугамд холбогдсон. УСУГ-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан.

1.5. Төслийн түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн

1.5.1. Байгалийн гаралтай түүхий эд

Үндсэн түүхий эд нь ямааны ноолуур, бөгөөд жилд 1000 тн ямааны ноолууранд гүн боловсруулалт хийж эцсийн ба завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэн 80%-ийг нь зах зээл өндөр хөгжсөн 30 гаруй орны 140-өөд харилцагчдадаа экспортлодогос гадаад дотоодын зах зээлд борлуулж байна.

Туслах түүхий эд, материал

Ноолууранд гүн боловсруулалт хийх ноолууран сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 129 төрлийн химийн болон туслах материал хэрэглэдэг.

Эдгээр будаг, химийн бодис бусад туслах материалуудыг Япон, ОХУ, Хятад, Итали, Швейцарь, Англи, Герман зэрэг орноос авдаг ба зориулалтын химийн бодисын агуулахад хадгалдаг.



Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх байгалийн гаралтай түүхий эд

Энэхүү төсөл нь үндсэн үйл ажиллагаандаа байгалийн баялгаас ус ашиглана. “Говь” ХК нь усаар хангагдах нөхцөлөөр II-р зэрэглэлийн объектод ордог бөгөөд үйлдвэр нь ус хангамжийг 3 зориулалтаар ашигладаг. Үүнд:

1. Үйлдвэрийн техникийн болон технологийн хэрэгцээнд
2. Ахуйн хэрэгцээнд
3. Усалгаа, гал унтраах зориулалтаар

Ус хэрэглээг төвлөрсөн шугамнаас хангадаг бөгөөд ус зөөлрүүлэгч 1 ба 2-р шатны шүүгчийг 2009 оны 4-р сард ашиглалтанд оруулсан. Зөөлрүүлэгч нь усны хатуулгийг 2 дахин бууруулснаар үйлдвэрийн усны хатуулаг 2.5 мг-экв/л хүрч ноос ноолуурын бүтээгдэхүүний чанарт нөлөөлж усны стандартын шаардлагыг бүрэн хангасан.

Мөн үйлдвэрийн барилга нь ус хангамжийн системд холбогдсон 3 цэгээс гал унтраах усыг авах боломжтой ба гал унтраах ПК-20 ширхэг, 2 насостой ба гал тэсвэрлэлтээрээ А зэрэглэлд багтдаг ба гал унтраах бүрэн ажиллагааны системтэй.

Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан хянаж, усыг ариг гамтай, үр ашигтай зарцуулах зорилгоор усны тоолуурыг тогтоосон хугацаанд стандарчлал, хэмжил зүйн газраар баталгаажуулдаг.

Усны хэрэглээний тооцоо: Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийг жилд тасралтгүй бүрэн хүчин чадлаар ажиллахад зарцуулах усны хэмжээг БОАЖЯ-ын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцож хүснэгт 2-д харуулав. Үйлдвэрт нийт 1650 хүн ажиллах боловч нэг өдөрт 1500 хүн ажиллахаар тооцоо хийв .



Үйлдвэрийн 2025 оны нийт ус хэрэглээний тооцоо

Хүснэгт 5 Усны хэрэглээний тооцоо

№	Ус ашиглалт	Хүчин чадал	Ус ашиглалт %	Ус хэрэглээний норм	Хоногийн ус хэрэглээ, м ³	Жилийн нийт ус хэрэглээ, м ³
1	АШҮ-Угаах	336.9 тн/жил	15%		195	14271
2	Ээрмэлийн үйлдвэр Будах, Холих	336.9 тн/жил	21%	136.1 /м ³ /	128	45615
3	Нэхмэл, Сүлжмэл, Оёмолын үйлдвэр	493120 ш/жил	21%	24.8 /1000 ш/	34	23051
4	Унд, ахуйн хэрэглээ	1500 хүн	15%	180 л	234	17566
5	Зүлэг, талбайн усалгаа 10%	8000 м ²	1%	4 л	32	960
Нийт					623	101463

АШҮ-15%-Хоногт 195тн ус Будах ээрэх холих-21%, Нэхмэл Сүлжмэл Оёмол-21%, Бусад-16% **Жич:** Зүлэг, зам талбайн усалгаа өдөр бүр хийгдэхгүй, жилд дунджаар хуурайшилттай үед 30 хоногт хийгдэнэ гэж тооцсон болно.

1.6. Төслөөс гарах хог хаягдал

Говь ХК нь ноос, ноолуурыг анхан шатнаас нь эцсийн бүтээгдэхүүн хүртэл бүрэн боловсруулах төсөр гүн боловсруулалтын үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд түүхий эдийн онцлогоос хамааран анхан шатны боловсруулалтын үе шатанд тодорхой хэмжээний байгалийн гаралтай бохирдол дагалддаг. Судалгаагаар гүйцэт шалгагдсан түүхий эд нь 40–42% хүртэл хэмжээтэй хольцтой байдаг нь олон улсын түгээмэл үзүүлэлттэй тохирдог.



Анхан шатны хольц бохирдолд дараах зүйлс багтдаг:

- Амьтны гаралтай бохирдол: ноосны тос (зунгаг), хага
- Байгалийн гаралтай хольц: элс, тоос шороо, ургамлын үлдэгдэл
- Бусад бохирдол: өтөг бууц, хатуу жижиг хог хаягдал

Эдгээр бохирдол нь дараах үндсэн технологийн үе шатуудын явцад бүрэн цэвэрлэгддэг:

- Ангилан ялгах, сэгсрэх – хатуу хольц, тоос, элс ялгарна
- Угаах – зунгаг, бохирдсон тос, биологийн гаралтай хольцгүй болгоно
- Хялгас ялгах – бүтэц муутай, ашиглалтын шаардлага хангахгүй хялгасуудыг механик аргаар салгана

Ноос, ноолуур нь цаашдын боловсруулалтын шатуудад — пресслэх, хатаах, будах, холих, самнах, ээрэх, нэхэх, сүлжих, гүйцэтгэн боловсруулах — механик, химийн, органик гаралтай тодорхой төрлийн хатуу болон шингэн хог хаягдал үүсгэдэг. Эдгээр хаягдалд:

- Самнах, ээрэх үед үүсэх утасны үлдэгдэл
- Сүлжих, нэхэх шатанд гарах хасагдал
- Будах, угаах явцад үүсэх халуун ус, органик хольцтой бохир ус
- Химийн бодисын үлдэгдэл (ISO 14001 стандартад нийцсэн хяналтын дагуу удирддаг)
- Үйлдвэрлэлийн механик засварын хаягдал

Говь ХК нь эдгээр хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй, зохистой хэлбэрээр удирдах зорилгоор ангилан ялгалт, дахин ашиглалт, дахин боловсруулалт, хаягдал усны цэвэрлэгээ зэрэг менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Түүхий эдийн бохирдлыг бүрэн цэвэрлэх технологи, үйлдвэрлэлийн үе шат бүр дэх хог хаягдлын хяналт нь компанийн тогтвортой үйлдвэрлэлийн бодлогын нэг чухал хэсэг юм.

1.6.1.Хатуу хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн, технологийн гаралтай хог хаягдал гарна. Энэхүү ахуйн хог хаягдлыг зохих журмын дагуу устгадаг байх бодлого баримтална.

Ахуйн хатуу хог хаягдалд: Цайны газрын хоолны үлдэгдэл, хүнсний зүйлийн үлдэгдэл, цаас, хуванцар, сав баглаа боодол, бусад хаягдлууд орно. Засгийн газрын 2015 оны 288



дугаар тогтоолын хавсралт **ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ТОГТООХ АРГАЧЛАЛ**-ын дагуу жилд гарах хатуу хогийг тооцно.

L- жилд гарах нийт хог хаягдал;

V- нэг өдөрт гарах хог хаягдлын норматив хэмжээ;

N- тооцох нэгжийн нийлбэр;

A- жилд ажиллах өдрийн тоо. Иймд ахуйн гаралтай, дахин ашиглах боломжтой хатуу хог хаягдлыг ангилж ялгаж хогийн цэгт төвлөрүүлэн гэрээний дагуу зайлуулах нь чухал.

Технологийн хатуу хог хаягдал буюу цэвэрлэх байгууламжаас гарч байгаа лаг шавар багтана. Эдгээрийг хуулийн зохицуулалтын шаардлагын дагуу устгах. Дахин боловсруулах боломжуудыг судлах.

Шингэн хаягдал

“Говь” ХК нь жилд дунджаар 96 мянган м³ бохир ус гаргахаар тооцоо байна. Бохир ус нь Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдэн насосоор хотын төвлөрсөн бохирын шугам руу шахагдана.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас гарах гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал газрын гадрага хэвлий, агаар гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, амьтны аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлдог.

Хөрсөн бүрхэвч

- Хатуу хог хаягдал хадгалах цэг нь стандартын шаардлага хангаагүй байгаагаас хөрс бохирдох
- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр шинээр эрүүл талбай өртөх
- Шинээр барилга байгууламж барих явцад ашиглах түр зам, барилгын талбай гаргах зэргээр хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөнө
- Үйлдвэрийн хаягдал, барилгын материалын хаягдал зэргээс хөрсөнд сөргөөр нөлөөлөх
- Эзэмшил талбайд шинээр барилга байгууламж нэмж баригдах газрын гадаргад сөрөг нөлөөлөл үүсэх



Агаарын чанар

- Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий.
- Төслийн талбайн нь хотын үйлдвэрлэлийн бүс нэлээдгүй сайн хөгжсөн бүсэд хамаарагдаж байгаа ба эхэн талбай нь хатуу хучилттай бусад хэсгийн ногоон байгууламж үүсгэсэн тул эзэмшил талбайгаас тоосжилт үүсэх магадлал.
- Төслийн үйл ажиллагаанаас үүдэн орчны агаарт ямар нэгэн хорт хий ялгарах
- Төслийн үйл ажиллагаанаас болж үүдэн ойр орчимд дуу шуугианы бохирдол үүсэх
- Ажлын байрны дотоод орчинд дуу шуугианы бохирдол үүсэх
- Зарим дамжлагад тоосжилт үүсэж ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх

Усан орчин

- Усны нөөцийн хомсдол
- Усны бохирдол
- Үйлдвэрийн технологиос гарсан хаягдал усаар ньусан орчин бохирдох
- Төслийн үйл ажиллагаанаас гадаргын усны урсац, голдиролд өөрчлөх, гол, булаг шанд бохирдох эсэх
- Ус таталтын шугам хоолойгоор ус алдагдах

Хүний эрүүл мэнд

- Тоосжилт
- Дуу чимээний бохирдол

3.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилт тавин байгаль орчинд учир болох сөрөг нөлөөллийг хянан ажилласан.

3.1.1 Агаарын бохирдолтоос хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гадаад орчны агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Захиргаа үйлчилгээний хэлтэс (ЗҮХ) нэгжид харьяалагддаг машин, механизмын техникийн хэвийн ажиллагааг хангаж үзлэг, оношилгоонд тогтмол хугацаанд хамруулан, шатах тослох



материалын зохистой хэрэглээг хангаж Үйлдвэрийн хэрэгцээнд байдаг автомашинуудыг HYBRID хөдөлгүүртэй шатахууны зарцуулалт бага машинуудаар солих ажлууд хийгдсэн.

Хүснэгт 6

№	Улсын дугаар	Тээврийн хэрэгслийн нэр	Ашиглалт	Жолоочийн нэрс
ЗАХИРЛУУД				
1	93-99 УНД	Toyota Lexus 570	Б.Амарсайхан	Долод
1	08-34 УЕК	Toyota Land cruiser LX300	Б.Болормаа	Баттүшиг
2	55-15 УБС	Toyota Lexus-570	Л.Саран	Даваасүрэн
3	24-67 УАК	Toyota Land Cruiser- 200	Г.Анударь	Мягмардорж
4	46-74 УБИ	Toyota Land Cruiser- 200	Т.Ичинхорлоо	Болдбаатар
5	76-98 УЕК	Geely Coolray GF 2WD	Д.Содгэрэл	Нармандах
6	76-98 УЕН	Geely Coolray GF 2WD	А.Учрал	Бямбадоньд
7	95-24 УБЯ	Geely Tugella GF AWD	Б.Чингүүн	Баатарсүрэн
ҮЙЛДВЭР ИТХ ДАРГА НАР				
8	38-45 УНБ	Toyota Landcruizer-76	Амаржаргал	ИТХ дарга
9	89-30 УБЭ	Toyota Prius-30	Оюунбилэг	Сүлжмэл дарга
10	06-31 УНЗ	Toyota Prius-30	Гэрэлцэцэг	Ээрмэл дарга
11	45-05 УБЕ	Toyota Prius-30	Дуламсүрэн	Нэхмэл дарга
12	52-86 УБҮ	Toyota Prius-30	Отгонжаргал	Нисэх менежер
13	16-02 УНЕ	Toyota Prius-30	Отгонцэцэг	Оёмол дарга
КОМПАНИЙН ДОТООД ҮЙЛЧИЛГЭЭНД				
14	88-58 УНВ	Toyota Land Cruzier- 200	Контент зураг авалт/ноолуур авах	Нямбаяр



15	24-77 УНР	Toyota Hiace	Контент зураг авалт	Нямбаяр
16	10-93 УНВ	Hino Dutro	Тээвэр том оврын ачаанд	Намдагпэрлий
17	32-60 УКК	Майти ачааны автомашин	Тээвэр том оврын ачаанд	
18	39-02 УНО	Hyundai Starex	Тээвэр дунд оврын ачаанд	
19	91-57 УБД	Toyota Prius-30	Тээвэр гаалийн бүрдүүлэлт	
20	82-24 УБЕ	Хьюндай Старекс 2018	Хангамжийн материал цуглуулах	Даваасүрэн
21	70-15 УБК	Toyota Naice	Хими цэвэрлэгээний түгээлт	Батсайхан
22	39-91 УБХ	VW Crafter	Дотоод борлуулалт түгээлт	Хасбаатар
23	97-18 УКА	Ford Transit	Дотоод борлуулалт түгээлт	Хасбаатар
24	23-94 УНП	Toyota Prius-50	Дотоод борлуулалт нисэх	Отгонбат
25	52-40 УНГ	Toyota Prius-30	Говь Гоёо дундын такси	Батсайхан
26	26-57 УНП	Toyota Prius-50	гражид зарах /91-57-г солино/	Нямбаяр
27	95-29 УНГ	Toyota Prius-30	гражид зарах /91-57-г солино/	Нямбаяр
28	75-54 УБР	Toyota Prius-30	гражид Оёмолын засварчинд	Нямбаяр
29	34-63 УНП	Toyota Prius-50	гражид дугаар явахгүй үед ашиглана	Нямбаяр
30	63-13 УНН	Geely Tugella GF AWD	Зочин тосох үед ашиглана	Нармандах

Манай байгууллага нь 2 чиглэлд 3 автобусаар өглөө, оройд ажилчдыг ажил, гэр гэсэн маршрутын дагуу нийтийн тээврээр үйлчилдэг. Үүгээрээ бид 1000 гаруй ажилчдын хувийн унаагаар ирж очих нөхцөлийг бууруулснаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгахад хувь нэмрээ оруулж байна.




**ЗҮҮН
ЧИГЛЭЛИЙН МАРШРУТ**



- 1 06:40 — Улаанбаатар дээд сургууль
- 2 06:44 — Өгөөмөр зах
- 3 06:48 — Аюулгүй тойрог
- 4 06:50 — Офицеруудын ордон
- 5 06:53 — Баянзүрх дүүрэг
- 6 06:56 — Кино үйлдвэр
- 7 06:59 — 13-р хороолол
- 8 07:02 — Бөхийн өргөө
- 9 07:05 — СЭЗД дээд сургууль
- 10 07:08 — Багшийн дээд сургууль
- 11 07:11 — Баангол зочид буудал
- 12 07:14 — 120 буудал
- 13 07:17 — 19 буудал
- 14 07:20 — Говь оффис
- 15 07:25 — Говь оффис

● өглөөний цагийн хуваларь



**БАРУУН
ЧИГЛЭЛИЙН МАРШРУТ**



- 1 06:30 — Орбитын хуучин эцэс
- 2 06:35 — Гүүрийн буудал
- 3 06:37 — Өрхийн эмнэлэг
- 4 06:39 — 42-р сургууль
- 5 06:41 — Төлгойтын эцэс
- 6 06:43 — 7-р хороо
- 7 06:45 — Төлгойт шөнийн дэлгүүр
- 8 06:47 — 65-р дэлгүүр
- 9 06:49 — Их наран - 1
- 10 06:51 — Төлгойт 3
- 11 06:53 — 21-р сургууль
- 12 06:55 — Цахилгаан тээвэр
- 13 06:57 — Геологийн төв лаборатори
- 14 07:00 — Сүлжмэлийн үйлдвэр
- 15 07:02 — 32-р байр
- 16 07:04 — Хархорин
- 17 07:06 — Цамбагарав
- 18 07:10 — Саппоро
- 19 - — Говь оффис
- 20 07:40 — Говь оффис

● өглөөний цагийн хуваларь



**БАРУУН-БАЯНХОШУУ
ЧИГЛЭЛИЙН МАРШРУТ**



- 1 06:30 — Баянхошуу тойрог
- 2 06:32 — Завсарын буудал
- 3 06:34 — Жанцан
- 4 06:36 — Баянхошууны эцэс
- 5 06:38 — Зүүн салааны 1-р буудал
- 6 06:40 — Баянхошууны хуучин эцэс
- 7 06:42 — 7-р хороо
- 8 06:44 — Цэргийн анги
- 9 06:46 — Хилчин хотгон
- 10 06:48 — Шинэ давхар
- 11 06:50 — Өндөр настан
- 12 06:52 — Давхар дэлгүүр
- 13 06:57 — Сонгино-хайрхан дүүрэг
- 14 07:00 — 21-р хороолол
- 15 07:02 — Цахилгаан тээвэр
- 16 07:04 — Геологийн төв лаборатори
- 17 07:06 — Сүлжмэлийн үйлдвэр
- 18 07:40 — Говь оффис

● өглөөний цагийн хуваларь

Зураг 20 Автобусны чиглэл



3.2 НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Говь ХК нь “Хөрс хамгаалалт, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7.2.4-т заасан шаардлагын дагуу эзэмшил газрынхаа 10 хувиас доошгүй талбайд зүлэгжүүлэлт, мод тарих ажлыг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү шаардлагыг хангахын зэрэгцээ компанийн гадаад орчны тохижилт, экологийн тэнцвэрт байдлыг сайжруулах, ажилтнуудын ая тухтай, эрүүл орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд ногоон байгууламжийг жил бүр нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг. 2025 онд гадаа талбайн ногоон байгууламжийн арчилгаа, нэмэгдүүлэлтийн ажлын хүрээнд дараах ажил хийгдлээ:

Одоогийн ногоон байгууламжийн арчилгаа, хэлбэржүүлэлт

- 112 ширхэг улиас мод
- 650 ширхэг хайлаас мод (ургамлын хашлагын зориулалттай)
Эдгээр модонд улирлын төлөвлөгөөт арчилгаа, хэлбэржүүлэлт, цэвэрлэгээний ажлууд хийгдсэн.

Шинээр хийсэн мод, ургамлын тарилт (2025 он)

Говь ХК-ийн гадна талбай, Хүрэн Монос байгууллагын урд хэсэгт дараах тарилтыг Эко мх саян ХХК-тай хамтран хийв.

- Нарс – 30 ширхэг
- Гацуур – 45 ширхэг
- Улиас – 10 ширхэг
- Мандлын цэцэг – 3,000 ширхэг
- Зүлэгжүүлэлт – 1,200 м²

Шинэ тарилт, зүлэгжүүлэлттэй хамт усалгааны горим, хөрсний хамгаалалтын дэвсгэрлэлт, улиралын арчилгааны ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Байгаль орчны эерэг үр нөлөө

- Үйлдвэрийн гаднах орчны тоосжилт, агаарын бохирдол буурч,
- Ногоон байгууламжийн нягтрал нэмэгдсэнээр микроклимат тогтворжиж,
- Ажилтнуудын ая тухтай ажиллах орчин сайжирч,
- Хөрсний элэгдэл, цөлжилтөөс хамгаалах экологийн хамгаалалтын функц бүрдэж,
- Хотын ногоон бүсийн талбай бодитоор тэлж байна.



Говь ХК нь цаашид ч жил бүр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод сөөгний амьдралтыг сайжруулах, хөрс хамгаалалтын арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэх зорилтыг баримталж ажиллана.



Зураг. 21 Том моддыг хэлбэршүүлж байгаа байдал



Зураг.22 Гадаа талбайд мандалын цэцэг болон зүлэгжүүлэлт хийсэн байдал



Зураг.23 Гадаа талбайд мандалын цэцэг болон зүлэгжүүлэлт хийсэн байдал



3.1.3 Усан орчныг хамгаалах

“Говь” ХК нь усны нөөцийг зүй зохистой ашиглах, бохир усны боловсруулалтын чанарыг сайжруулах, байгаль орчны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгож байна. Үүний хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Ус ашиглалтын зөвшөөрөл, хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт

- 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аас ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглалтын үйл ажиллагааг холбогдох журмын дагуу явуулж байна.
- 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хаягдал усны дүгнэлт гаргуулж, бохир усны бүртгэл, хяналтын байдлыг сайжруулсан бөгөөд үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн оролт, гаралт дээр бохир усны бохирдлын хэмжээг хянах төхөөрөмжийг суурьлуулав.
- 2024 оны ус ашиглах дүгнэлтийг БОННУ тухайн аны 4-р сарын 16нд батлагдсантай холбогдуулан ус ашиглах дүгнэл гаргуулаагүй байсан зөрчлийг холбогдох журмын дагуу нөхөн гаргуулсан.



Зураг.24 Говь ХК-ийн ус ашиглах зөвшөөрөл



Ус ашиглалтын хэмжээ ба төлбөрийн бүртгэл

2024 онд компанийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд нийт 101,600 тонн цэвэр ус ашигласан бөгөөд ус ашигласны төлбөр, байгалийн нөөцийн төлбөрийг хууль тогтоомжийн дагуу бүрэн төлсөн. Үүнд:

- Усны төлбөр: 436,281,823 төгрөг
- Байгалийн нөөц ашигласны төлбөр: 11,007,040 төгрөг

Тайлагнал, төлбөрийн мэдээллийг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, хяналтыг бүрэн ханган ажиллаж байна.

Ус хэмнэх арга хэмжээнүүд

Компанийн хэмжээнд усны хэрэглээг бууруулах, хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг тогтмол хэрэгжүүлж байна:

- Сан техникийн шугам сүлжээний засвар үйлчилгээг төлөвлөгөөт байдлаар хийж, усны алдагдлыг бууруулав.
- Үйлдвэрийн усны хэрэглээний горимын судалгаа хийж, усны хэрэглээ өндөртэй хэсгүүдэд:
 - Усыг хэмнэлттэй ашиглах технологийн зааварчилгаа,
 - Хэмнэлтийн горимын удирдамжийг боловсруулан мөрдүүлсэн.
- Усны хэрэглээний мэдээлэлд үндэслэн хяналтын систем сайжруулж, хэрэглээний тоон үзүүлэлтүүд дээр тогтмол дүн шинжилгээ хийж байна.

Бохир ус цэвэрлэгээ ба дахин ашиглалт

Компанийн бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж, шинэчлэгдсэн байгууламжийг ашиглалтад оруулсан. Шинэ байгууламж нь олон улсын шаардлагад нийцсэн цэвэрлэгээний түвшинтэй бөгөөд дараах давуу талуудыг бий болгосон:



- Цэвэршүүлсэн бохир усыг халдваргүйжүүлэн, цэвэрлэх байгууламжийн дотоод хэрэгцээнд эргүүлэн ашиглаж, цэвэр усны хэрэглээг бууруулах боломж бүрдсэн.
- Байгаль орчинд нийлүүлэх бохир усны ачаалал буурч, усны чанарын үзүүлэлтүүд тогтмол хяналт-шинжилгээнд хамрагдаж байна.



Зураг.25 Говь ХК-ийн цэвэр усны хэрэглээ

Усны зохистой хэрэглээ ба хэмнэлт

Ундны цэвэр ус болон хаягдал бохир усны чанарыг байнга хянаж, чанарт нь тогтмол шинжилгээ хийдэг. Энэ нь компанийн байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг хангах, усны нөөцийг зөв ашиглах, бохирдлыг бууруулах зорилготой юм. Шинжилгээ нь усны чанар, бохирдлын түвшинг тодорхойлж, тухайн усны хэрэглээний зориулалтад тохирсон эсэхийг шалгахад чиглэдэг.

Цэвэр усны шинжилгээ

Ундны усны чанар нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болохоор эмнэлгийн болон эрүүл ахуйн шаардлагыг хангах ёстой. Тиймээс Говь ХК ундны усны хүнд металлын агууламж, бактерийн агуулга, рН түвшин, хлор, хлорид, хүчилтөрөгчийн агууламж зэргийг шинжилдэг.

Хаягдал бохир усны шинжилгээ



Хаягдал усны чанар нь байгаль орчны эрсдлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой. Хаягдал бохир усыг дахин боловсруулах, эко-найдвартай байдлаар устгах шаардлагатай. Тиймээс хаягдал усны рН, хүнд металлын агууламж, органик бодис, бактери, бохирдлын түвшнүүдийг тогтмол шалгаж, хяналт тавьж ажилдаг.

Говь ХК ус хэмнэх талаар ажилтнуудад мэдлэг ойлголт өгөхөд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тус сургалтууд нь усны хэмнэлттэй холбоотой тодорхой аргачлал, дадал хэвшлийг ажилтнуудад танилцуулж, усны хэрэглээг хэмнэх ач холбогдлын талаар видео контент болон мэдээлэл түгээдэг.

Усыг хэмнэх дараахь боломж, арга замууд байна гэж үзсэн

1. Цэвэрлэх байгууламжийн шинэчлэх саарал усыг ашиглах
2. Технологийн зарим дамжлагын усыг дахин ашиглах
3. Усны хэмнэлттэй тоног төхөөрөмж ашиглах

Цэвэрлэх байгууламж

“ 2020 оны 1-р сард хоногт 250 м3 ус цэвэршүүлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж Анхан шатны үйлдвэрийн угаах болон ноолуур будах үйлдвэрлэлээс гарсан бохир усыг ариутгах татуургын стандартад нийцүүлэн цэвэршүүлжтай байсан бөгөөд Говь ХК нь 2024 онд байгаль орчны хуулийн нийцэл болоод тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд томоохон хөрөнгө оруулалт хийсний нэг нь үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж шинээр барих төсөл юм. 2024 онд "Эгц шугам" ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж эхлүүлсэн бөгөөд энэхүү төслийн байгууламж нь:


- Хоногт 228 м3 бохир ус цэвэршүүлэх хүчин чадалтай,
- MNS 6561 стандартын дагуу L2 түвшний MBBR технологитой,
- Хүний хөдөлмөрийг хөнгөвчилсэн бүрэн автоматжуулсан, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжтэй,
- Цаашид төслийг өргөжүүлэн саарал ус гарган авах боломжтой байхаар төлөвлөгдсөн.



Технологи: Механик – Физик, Хими – Биологи цэвэрлэгээ



Зураг.26 Бохи́р ус цэвэршүүлэх байгууламжийн зураг



Зураг.27 Цэвэрлэх байгууламжийг сайжруулах төслийн технологийн схем зураг

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 10 дугаар сарын 10 Дугаар 6А-556/2025 Улаанбаатар хот

Нэг, Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-уул дүүргийн 3 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок, үйлдвэрийн бохир ус цэвэрлэх зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засяг дэргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр, Ерөнхий мэдээлэл

2.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2025/08/08 огноо, БА3Г/2025/0726 дугаар;

2.2.Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: КП-24-02;

2.3.Захиалагч: Говь ХК оноосон нэр, 9010001061 улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2076357 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр 70139917,70048888 холбоо барих утас, info@gobi.mn цахим хаяг;

2.4.Барилгын ажлын гүйцэтгэгч: Эгц шугам ХХК оноосон нэр, 5312825 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2582635 регистрийн дугаар, БУ12-125/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо Эрдэнэтолгойт гудамж, 96002129 холбоо барих утас, batsaikhand4747@gmail.com цахим хаяг;

2.5.Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Киото партнерс ХХК оноосон нэр, 3770834 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 3Т36-852/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Хан-Уул таур, 9-р давхар, 901 тоот, 89107780 холбоо барих утас, kyotopartners@gmail.com цахим хаяг;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, Говь ХК оноосон нэр, 9010001061 улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2076357 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр 70139917,70048888 холбоо барих утас, info@gobi.mn цахим хаяг;

3.4.Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв, Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок, үйлдвэрийн бохир ус цэвэрлэх зориулалттай барилгын байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-уул дүүргийн 3 дугаар хороо, Говь ХК-ийн захиалгатай, Зоорьгүй 1 давхар 1 блок, үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын
албан үүргийг гүйцэтгэгч
(А.Менген)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Говь ХК-ийн
Дизайн, үйлдвэрлэл харууцсан дэд захирал
(Б.Болормаа)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

Зураг.28 Цэвэрлэх байгууламжийн улсын комисс хүлээн авсан дүгнэлт



Технологийн зарим дамжлагын усыг дахин ашиглах боломжууд

“Говь” ХК-ийн хэмжээнд Угаах, Будах, Холих, Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулах, Принт, Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах, Хими цэвэрлэгээ зэрэг 7 дамжлагуудад нойтон боловсруулалтанд хийгддэг. Тэдгээрийн технологийн дамжлагын сүүлийн хэсгүүдээс хаягддаг уснуудаас дахин ашиглах боломж байгаа эсэхийг судлаж бохир усны шинжилгээнд дүгнэлт хийв.

Нойтон боловсруулалт хийдэг алба нэгжүүдэд хэрэглэдэг технологийн зориулалттай усны чанарын шаардлага

№	Дамжлагууд	Усны төрөл	Усанд байвал зохих үзүүлэлтүүд	
			Хатуулаг (мг*эkv/л)	Орчин (pH)
1	Угаах	Зөөлрүүлсэн ус	3	6-8
2	Будах	Зөөлрүүлсэн ус	2	6-8
3	Холих	Зөөлрүүлсэн ус	2	6-8
4	Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулах	Зөөлрүүлсэн ус	3	6-8
5	Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах	Крантны ус	-	-
6	Принт	Ус шүүгчнээс	-	-
7	Хими цэвэрлэгээ	Крантны ус	-	-

Угаах, баглах алба: Угаах дамжлагад хэрэглэгдэж буй усыг заавал зөөлрүүлсэн байх бөгөөд дээрх 9 дээжний үзүүлэлтээс харахад будах албаны зайлалт 2,3-ийн усны хатуулаг нь 3.0мг*эkv/л-т багтаж байгаа хэдийч pH=9.27-9.61 байна, СБА, НБА-ны pH=5.29-7.66 байгаа хэдийч усны хатуулаг нь 3.94-6.81мг*эkv/л байна. Иймээс АШҮ-ийн УБА-нд бусад албанд ашигласан усыг ашиглах боломжгүй гэж үзэж байна. Үүнээс гадна угаах дээр усыг дахин ашиглаж байгаа. Угаах нь IV онгоцтой бөгөөд тус бүр 5400-7900л багтаамжтай. Түүхий эдийг угаахдаа I-р онгоцонд дэвтээлт, II онгоцонд савангийн уусмалын



тусламжтайгаар зунгаг бохирдлоос нь салгах, III, IV-р онгоцонд зайлалт хийгддэг бөгөөд угаалт хийх явцад усны сэлгэлт хийх шаардлагатай байдаг. Иймд IV-р онгоцонд худгаас цэвэр ус /зөөлрүүлсэн/ татаж сэлгэдэг. III-р онгоцны усыг сэлгэхдээ IV-р онгоцноос, II онгоцны усыг III-р онгоцноос, I-р онгоцны усыг II-р онгоцноос татаж сэлгэлтийг хийж усаа дахин ашигладаг. I онгоцны ус нь бохирдол, булингар ихтэй байдаг тул шууд асгадаг. Ийнхүү дахин ашиглаж усаа хэмнэж байна.

Ус хэмнэлттэй ашиглах цорго

Ариун цэврийн өрөөнүүдэд нийт 20 ширхэг цорго суурилуулсан 1 цорго нэг удаа гар угаах усны 70% хэмнэх бөгөөд үйлдвэр нийт 1291 орчим ажилтан өдөрт 3 удаа гараа угаадаг гэж үзвэл 12910 литр ус зарцуулна. Түүний 70% хэмнэсэн гэхээр 9037 литр ус цорго суурилуулсанаар зөвхөн ажилчид гар нүүрээ угаахад хэмнэж чадаж байна.

Агааржуулалтын хөргөлтийн усыг угаахад дахин ашиглах

Агаар 1, 2 хөргөлтийн усыг мэдрэгчтэй гоном, соронзон хаалт, автомат удирдлагын самбарын тусламжтайгаар Угаах цехид дахин ашигласанаар сард угаах цехийн ашиглах усны 5%-г хангаж чадаж байна.

Агааржуулалтын хөргөлтийн усыг угаахад дахин ашиглах

Агаар 1, 2 хөргөлтийн усыг мэдрэгчтэй гоном, соронзон хаалт, автомат удирдлагын самбарын тусламжтайгаар Угаах цехид дахин ашигласанаар сард угаах цехийн ашиглах усны 5%-г хангаж чадаж байна.


3.1.4 Эрчим хүч хэмнэлтийн ажлууд

Говь ХК нь нийт 513,9 мянган м3 эзэлхүүн бүхий барилга байгууламжтай. Үүний 82% үйлдвэрийн 10% агуулхын, 8% оффис үйлчилгээний зориулалттай барилга эзэлнэ. Нийт 3500 гаруй нэр төрлийн цахилгаан болон уураар ажилладаг тоног төхөөрөмжтэй. Манай байгууллага нь сүүлийн 3 жилийн дунджаар жилд 25 сая кВт.цаг эрчим хүч зарцуулсан байна. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 оны эрчим хүч хэмнэлтийн төлөвлгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг:



2024 оны эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөний дагуу Говь, Гоёо үйлдвэрийн коридорын гэрэлтүүлгийг 4.1 сая төгрөгийн зардлаар 70 ширхэг хөдөлгөөн мэдрэгчтэй LED гэрлээр сольж сайжруулсан. Ажлыг 2024 оны 7 сард хийж гүйцэтгэсэн.



Зураг 29. LED гэрэл худалдан авсан баримт, хэмнэлттэй гэрэл суурьлуулав

Өмнөх 70 ширхэг 40 Вт-н LED гэрлийг хөдөлгөөн мэдрэгчтэй 18 Вт-н LED гэрлээр сольсноор жилд ойролцоогоор 16.7 МВт.ц цахилгаан, 3.3 сая төгрөгийн хэмнэлт хийх тооцоо гарсан.

Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр ашиглах боломжийн судалгаа

Нийт эрчим хүчний хэрэглээний тодорхой хувийг байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгаруулалтгүй цэвэр эрчим хүчийг өөрсдөө үйлдвэрлэн хэрэглэх зорилгоор Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, оргил цагийн ачааллыг хөнгөлөх зорилгоор UNILEAD компанитай хамтран нарны хавтан суурилуулах төслийн тооцооллыг хийж байна

Судалгааны үр дүнд зорилтод талбайд 260 кВт-2121.6 Квт хүчин чадал бүхий систем суурьлуулах боломжтой гэсэн тооцоолол гарсан бөгөөд уг системийг ашиглалтанд оруулснаар жилд дунджаар цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний 36,3% хэмнэх боломжтой.

	Үйлдвэр	Төв дэлгүүр	Авто машины зогсоол
Талбай	21,318м ²	2,016м ²	366м ²
Барилгын бүтэц	Тоосгон дүүргэлттэй төмөр карказ	Төмөр бетон	-
Суурилуулах боломжит нарны хавтангийн хэмжээ	Дээд хэмжээ 2121.6 кВт	Дээд хэмжээ 260 кВт	Дээд хэмжээ 221.13 кВт



Жилд үйлдвэрлэх эрчим хүчний хэмжээ	Дээд хэмжээ 2.377 ГВтц	Дээд хэмжээ 279.7 МВтц	Дээд хэмжээ 249.0 МВтц
-------------------------------------	---------------------------	---------------------------	---------------------------



Зураг.30 Нарны панел суулаах боломжит хувилбар

Ажилтнуудын чадавхжуулалт:

- Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар нийт ажилтнуудад сургалт контент зааварчилгаа тогтмол хүргүүлдэг.
- Сургалтаар эрчим хүчний зохистой хэрэглээ, хэмнэлтийн ач холбогдлыг ойлгуулж, практик аргачлалуудыг зөвөлдөг.
- Эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар улирал бүр үйлдвэр оффиссуудад хяналт тавьж, зөвлөмж зааварчилгаа хүргүүлэн ажилладаг.


Эрчим хүчний зохистой хэрэглээг таниулах видео контент

“Эрчим хүчний зохистой хэрэглээ” видео контентыг компанийн “Контентын хэлтэс”-тэй хамтран бэлтгэж, дотоод сувгууд болон ажилчдын мэйлээр бүх ажилчдад хүргэлээ. Энэхүү видеог 2025 оны 3 сард бэлтгэж, түгээсэн бөгөөд дараах гурван агуулгыг багтаасан:

1. Эрчим хүч хэмнэх энгийн аргачлалуудыг хэвшил болгох
2. Хэмнэлттэй хэрэглээг урьдчилан төлөвлөх
3. Оргил ачааллын цагаар эрчим хүчээ хэмнэх



Видео контент нь ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, эрчим хүч хэмнэх дадал бий болгоход нөлөөлсөн.



Зураг 31. Эрчим хүч хэмнэх видео контент

Эрчим хүчний үр ашигтай менежментийг хангах тодорхой арга хэмжээ, шийдэл боловсруулах суурь мэдээлэл бүрдэж Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдаж, түүний хэрэгжилтэд хяналт тавих механизм бий болгов. Энэ ажлын үр дүнд Говь ХК нь эрчим хүчний хэрэглээгээ үр ашигтай удирдаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилтоо хэрэгжүүлэхэд дэвшилт гаргаж байна.

3.3 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говь ХК нь үйлдвэрлэлийн бүхий л үе шатандаа байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай байдлыг эрхэмлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглахыг зорьдог. Энэ хүрээнд, бид үйл ажиллагаанаасаа ялгаруулж буй хүлэмжийн хийг бууруулах зорилгоор жил бүр мод тарих уламжлалаа үргэлжлүүлсээр байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тусгагдсаны дагуу Нийслэлийн байгаль орчны газрын хуваарилсан координат бүхий талбай ХУД-ын 21-р хороо Айцын аманд мод тарих ажлыг технологийн дагуу тарилтыг хийж гүйцэтгэсэн. Мэргэжлийн байгууллагатай хамтран НБОГ-аас олгосон координат бүхий талбайд мод үржүүлгийн газраас шинэс мод 50 ширхэг, Улиас мод 150 ширхэг мод авчирч шилжүүлэн суулгасан. Моддыг технологийн дагуу ухаж бэлтгэсэн нүхэнд хөрсийг



бэлтгэхдээ хар шороо 50%, элс 30%, бууц 20% найрлагатай багсарч найруулан тарилтыг хийж гүйцэтгэсэн. 200 ширхэг моддыг 50тн усалгааны машинаар усалгааг ханатал усалж тухайн газар дээр тарилт хийсэн талбайг ХУД-ын тохижилт үйлчилгээ ногоон байгууламжийн ажилтан Бат-Эрдэнэд Говь ХК-ийн БО-ны менежер хүлээлгэн өгсөн.



Зураг.32 Мод тарих нүх бэлтгэсэн байдал



Зураг.33 Мод тарьсан байдал



3.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд тус дүүргийн засаг даргын 2017 оны 02 сарын 03-ны өдрийн А/55 тоот шийдвэрээр олгогдсон 178013/001 18639309696233 тоот нэгж талбарын дугаар бүхий үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших 49883 м2, 178013/0060 18639309770292 тоот нэгж талбарын дугаар бүхий конторын зориулалтаар эзэмших 4467 м2 талбайг 15 жилийн хугацаатай эзэмших эрхтэй байна.

Төслийг хэрэгжүүлэх 40 гаруй жилийн хугацаанд дүүрэг, хороо аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй байна.

3.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах болно.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.



3.6 ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говь ХК нь 2024 онд химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн болно. Манай байгуулга нь байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн үйл явц дахь химийн бодисын зохистой хэрэглээг хангах зорилгоор 2024 онд Геодата ХХК-тай хамтран үйл ажиллагаандаа ашиглаж буй химийн бодисууд дээр эрсдэлийн үнэлгээ хийлгэж, холбогдох тусгай зөвшөөрлийг авсан.



**Химийн хорт болон аюултай бодисыг
Илэрхийлэх, ашиглах 0002719
дугаартай тусгай зөвшөөрлийн амрамал**

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, тн
1	Лавсан	Ca(OH) ₂	Ca(OH) ₂ ·nH ₂ O	360770-21-04	7
2	Лавсан	Ca(OH) ₂	Ca(OH) ₂ ·nH ₂ O	152255-14-6	25
3	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
4	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
5	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
6	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
7	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
8	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
9	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
10	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
11	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
12	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
13	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
14	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
15	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
16	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
17	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
18	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
19	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
20	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
21	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
22	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
23	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
24	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8
25	Албегит B	Al ₂ O ₃	Al ₂ O ₃	09548-45-03	8

72	Техни CR12	Technical CR12	C ₂ H ₄ ·N ₂ O ₅	85117-50-6	7
73	Глицерин, цэвэр	Glycerol	C ₃ H ₈ O ₃	56-81-6	2
74	Налин, наалт	New soap	C ₁₈ H ₃₅ N ₂ O ₅ S	7782-40-3	2
75	Полуэтиленовийн үндэс PAM	Polymethylene powder	C ₂ H ₄ N ₂ O	9003-41-8	2
76	Полуэтиленовийн хлорид PAC	Polymethylene chloride	(C ₂ H ₃ Cl) _n	1327-41-9	22
77	Шингэн тос	Motor oil	(C ₁₂ H ₂₂ O) _n	68648-42-7	8
78	Энгийн тос	Marina	C ₁₂ H ₂₂ O	2644-45-5	8
79	Энгийн тос	Grease	C ₁₂ H ₂₂ O	115-96-6	2
80	Энгийн тос	Adhesive	C ₁₂ H ₂₂ O	58537-41-7	2
81	Энгийн тос	Hydro oil	C ₁₂ H ₂₂ O	54275-38-7	2
82	Энгийн тос	Motor oil	C ₁₂ H ₂₂ O	57555-77-3	2
83	Энгийн тос	Sewing machine oil	C ₁₂ H ₂₂ O	128-37-0	3
84	Энгийн тос	LUBRA	C ₁₂ H ₂₂ O	1330-79-5	3
85	Энгийн тос	Stoltes T 46	C ₁₂ H ₂₂ O	12537-0	2
86	Энгийн тос	Stoltes T 46	C ₁₂ H ₂₂ O	122-39-4	2
87	Энгийн тос	Teled	C ₁₂ H ₂₂ O	039-892-2	2
88	Энгийн тос	Compressor S	C ₁₂ H ₂₂ O	6941-46-1	3
89	Энгийн тос	Fluon	C ₁₂ H ₂₂ O	75-72-8	8
90	Энгийн тос	Fluon	C ₁₂ H ₂₂ O	08425-15-0	2
91	Энгийн тос	Silica gel	SiO ₂	7631-86-3	1

Зураг.34 Химийн бодисын тусгай зөвшөөрөл

Химийн бодисын агуулахад аюулгүй ажиллагааны заавар, тэмдэг, тэмдэглэгээг шинэчилж, олон улсын стандартад нийцүүлсэн. Химийн бодисын хэрэглээ, хадгалалт, устгалын талаар улирал бүр дотоод тайлан гаргаж хянадаг, Жилийн эцэст гардаг тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Химийн бодисын хэрэглээний процессоос ус, эрчим хүчний зарцуулалтыг бууруулах шийдлүүдийг нэвтрүүлэн. Ноолуур боловсруулах үе шатанд химийн бодисын цайруулалтыг багасгаж, байгаль орчинд ээлтэй будгийн технологи ашиглан ажиллаж байна.

Жил бүр химийн бодистой харьцан ажилладаг ажилтнуудыг химийн бодисын зохистой хэрэглээний сургалтад хамруулан мэдлэг ойлголт олгон хүний эрүүл мэнд, байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэн ажилладаг. Энэ жил Байгаль орчин судалгаа шинжилгээний төвөөс зохион байгуулсан Хүний эрүүл мэнд, байгаль орчинд химийн хорт болон аюултай бодисын сөрөг нөлөөлөл, эрсдэлийг тогтоох, үүсэж болох нөхцөл байдлыг урьдчилан таамаглах, эрсдэлийн дүр зургийг



аргачлалын дагуу тодорхойлох “Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ” сургалтад химийн бодис хариуцсан мэргэжилтэн хамрагдав.

Сургалтын агуулга химийн хортой аюултай бодисын эрсдэл, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөө, Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ, химийн бодистой харьцах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал сэдвийн хүрээнд явагдлаа.



Зураг 35 Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ сургалтанд хамрагдсан
сертификат



Аюултай хортой /хүчил, шүлт/ г.м. бодистой ажилладаг 12 ажилтан байдаг бөгөөд МЗ химийн баг, бээлий зэрэг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангасан бөгөөд ашиглалтын хугацааг сайтар бүртгэж хугацаа дууссан хамгаалалтын хэрэгсэлийг аюултай хог хаягдал устгах эрх бүхий байгуулгад шилжүүлэн устгуулдаг. Мөн химийн бодисийн асгаралтын үед ашиглах иж бүрдэлийг химийн бодис ашигладаг агуулах болон химийн бодис хадгалдаг цэгүүдэд байршуулав.




Зураг 36 Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл

2024 онд Байгаль орчны нөлөөлөлийн үнэлгээг хийлгэж Геодата ХХК-аар Химийн бодисын эрсдэлийн үнэлгээг Химийн бодисын агуулах дотор түр хадгалах өрөө, химийн бодис ашигладаг үйлдвэр, алба нэгжид хийгдсэн. Химийн бодисын агуулахын 432 м2 талбайг Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах /Ерөнхий шаардлага MNS 6458:2014/ Стандартын дагуу жил бүр шинэчлэлт сайжруулалтын ажил хийж байна. Үүнд:

- Химийн агуулахад бодисыг төрөлжүүлэн хурааж тусгаарлах хана тавиур хийгдсэн
- Химийн агуулахад мэдээлэлийн самбар аваарын гарцын хаалга гаргасан
- Химийн агуулахад галын эрсдэлээс сэргийлж утаа мэдрэгч болон галын дохиолол тавьсан
- Химийн агуулахад бодис асгарах болон хий алдагдсан үед, зохих түшинг хэтэрснийг дохиолол өгч мэдээлснээр хүний эрүүл мэнд аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах багаж суурьлуулав 2024 оны төсвөөр 37,484,00 төгрөг 3ш багаж авч суурилуулсан /Пи Эс СИ-ХХК худалдан авсан/



- Химийн бодисын асгаралт алдагдалтын үед авах арга хэмжээний гарын авлага боловсруулахад зориулж 91-н нэр төрлийн бодисын хор аюулын лавлагаа мэдээллийг орчуулан ХАЛМ бэлэн болж 91 бодис дээр шошгожуулалт гаргасан.



Зураг.37 Химийн бодисын агуулахын шинэчлэлт

Хяналт, тайлагналын систем:

- Химийн бодисын хэрэглээ, хадгалалт, устгалын талаар улирал бүр дотоод тайлан гаргаж, хяналт тавьдаг.
- Жилийн эцэст гарсан тайланг байгаль орчны болон химийн бодисын хяналтын холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Тайлангийн хүрээнд:
 - Ашигласан бодисын тоо хэмжээ.
 - Хадгалалт, тээвэрлэлтийн бүртгэл.
 - Хаягдлын зохицуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгасан.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд химийн бодисын менежмент, хэрэглээний аюулгүй байдлын түвшинг сайжруулсан алхмууд хийгдсэн байна. Цаашид энэхүү ажлуудыг



өргөжүүлэн, хяналтын системийг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.7 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говь ХК нь хог хаягдлын менежментийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор "Хаявал хог, ангилбал баялаг" уриатай хог хаягдлыг ангилгах системийг нэвтрүүлсэн. Энэхүү арга хэмжээ нь хог хаягдлыг зөв ангилж, дахин боловсруулах, устгах замаар байгаль орчинд ээлтэй арга барилуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Ажилтнуудын мэдлэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хог хаягдлын ангилалтыг өргөжүүлэх зорилгоор сургалт, гарын авлага зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна. Төслийн үйл ажиллагаанаас ахуйн, технологийн гаралтай хог хаягдал гарна. Энэхүү ахуйн хог хаягдлыг “Эко-Орчин ХХК-тай байгуулсан 01/83 тоот гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулдаг. Компанийн хэмжээнд хог хаягдлын менежмент нэвтрүүлэн хатуу хог хаягдлыг цаас, хуванцар, хүнсний хаягдал, бусад, батарейны хаягдал гэж 5 төрлөөр ангилж Recycle буюу дахин ашиглах боломжтой хаягдлыг ангилж 2026 оны 01-06 сар дуустал 5,247.1 кг цаасны хогийг "Агар тайж" ХХК-д, 563.7 кг гялгар уут, 2,353.7 кг хуванцар савыг "Мулти пак" ХХК, бусад 16,766,2 кг нийт 145 рейсээр гэрээт "Эко орчин" ХХК-иар тээвэрлэлт хийлгэн Морингийн давааны төвлөрсөн төв хогийн цэгт тушаасан.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь гарч буй хог хаягдлын төрлөөс шалтгаалан /дахивар, цаас, бусад/ ангилан ялгах хогийн савыг нийт үйлдвэр оффисын хэмжээнд дотор талбайд 34 байршилд 174 ширхэг, гадна талбайд 4 байршилд 12 ангилан ялгах хогийн сав байршуулсан.



ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТАЙЛАН /2025/

Он Сар	Говь-1, Гоёо					Тухайн сарын нийт хог хаягдал /кг/
	Цаас/кг/	Хуванцар /кг/	Гялгар /кг/	Бусад /кг/	Барилгын хог хаягдал /кг/	
2025.01	664.30	192.51	156.30	2,807.06	-	3,820.17
2025.02	483.30	184.30	132.30	2,671.40	36,800.00	40,271.30
2025.03	615.70	202.00	125.11	2,928.23	110,100.00	113,971.04
1-р улирал	1,763.30	578.81	413.71	8,406.69	146,900.00	158,062.51
2025.04	499.20	185.50	102.40	3,154.12	36,500.00	40,441.22
2025.05	568.80	178.40	115.60	2,804.10	48,000.00	51,666.90
2025.06	357.60	140.28	103.20	2,504.71	14,000.00	17,105.79
2-р улирал	1,425.60	504.18	321.20	8,462.93	98,500.00	109,213.91
2025.07	393.20	138.20	124.60	1,832.50	-	2,488.50
2025.08	429.80	178.60	116.70	2,768.70	17,000.00	20,493.80
2025.09	431.40	131.60	121.20	2,777.65	18,000.00	21,461.85
3-р улирал	1,254.40	448.40	362.50	7,378.85	35,000.00	44,444.15
Нийт дүн	4,443.30	1,531.39	1,097.41	24,248.47	280,400.00	311,720.57

Зураг.38 Гарсан хог хаягдлын гарцын мэдээ



Жилдээ 350 тн хог хаягдлыг “Эко-орчин ХХК”-д гэрээгээр шилжүүлэн үүний 26,3%-г дахин боловсруулалтад шилжүүлсэн. Аюултай хог хаягдлын БОАЖЯ-аас тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэн хяналт тавин байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэн ажлууд хийгдсэн.



*Зураг.39 Хог ачилтын үе болон морингийн даваа төвлөрсөн хогийн цэгт
буулгасан байдал*

Хогийн цэгийг жил бүр шинэчилж засаж сайжруулан хөрсөнд шингэхээс тусгаарлан битүүмжлэлтэй болгож хог хаягдлын цэг хүртэлх замыг хайрга дэвсэн сайжруулсан. Говь ХК-ийн үйлдвэрийн гадаа төвлөрсөн хогийн цэгийн шинэчлэн дахивар болон барилгын материал, аюултай хог хаягдал зэрэг түр хадгалах цэг шинээр бий болгосон.



Зураг.40 Хогийн цэгийн шинэчлэлт



Аюултай хог хаягдал болох зай хураагуурыг зориулалтын батерей цуглуулах хайрцагийг 2025 онд 12 цэгт байршуулан цуглуулаж байна. Үүгээрээ бид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ажилтан бүр батерей цуглуулах боломжийг бүрдүүлсэн.

Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай нийлүүлэн хөрс, агаар, усыг бохирдуулахаас сэргийлж 2025 онд 3000 ширхэг батерей цуглуулан Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгч мэргэжлийн байгууллагаар устгуулав.



Зураг.41 Хаягдал баттерей цуглуулах хайрцаг



Зураг.42 Хаягдал баттерей тээвэрлэлт хийж байгаа байдал


Хог хаягдлын менежментийн сургалт

Говь ХК нь Өнгө Нэм ТББ-тай хамтран 2025 онд хог хаягдлын менежментийн тухай нийт ажилчдад сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалт нь хог хаягдлыг зөв ангилах, устгах,



дахин боловсруулах болон байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийн практик арга барилуудыг ажилтнууддаа танилцуулах зорилготой байлаа.

Сургалт нь Говь ХК-ийн байгаль орчны бодлого болон тогтвортой хөгжлийн хүрээнд хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх чухал алхам болсон бөгөөд ажилчдын мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэв.



Зураг.43 Хог хаягдлын менежментийн сургалт

Гарын авлага

Манай байгууллага нь хог хаягдлын менежментийн талаар ажилтнууддаа зориулан гарын авлага гаргав. Энэ гарын авлагад хог хаягдлыг зөв ангилах, устгах, дахин боловсруулах болон байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийн арга барилуудыг тусгасан.

Гарын авлага нь компанийн хог хаягдлын менежментийн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ажилтнуудад хог хаягдлыг зөв зохистой хаяхад туслах зорилготой. Энэхүү гарын авлагыг компани доторхи үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, байгаль орчны хамгаалалтад хувь нэмэр оруулах үүднээс хэрэгжүүлж байна.



Зураг.44 Хог хаягдлын менежментийн гарын авлага



3.8 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говь ХК нь Байгаль орчны Удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг 2019 оноос үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Бид байгаль орчиндоо ээлтэй үйлдвэрлэгч байхын тулд байгууллагын бүхий л үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ногоон байх зарчмыг баримтлан МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн байгаль орчны бодлогоо тодорхойлж, Уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөллийг хүлээн зөвшөөрч, компанийн үйл ажилгааны экологийн ул мөрийг багасгахад онцгой анхаарч, байгалийн нөөцийн хэрэглээг зөв зохистой ашиглах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах арга барилыг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллана. 2024 онд “Говь” ХК-ийн удирдлагын зүгээс дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн:

1. БО-ны удирдлагын тогтолцооны ISO14001 баталгаажуулалт
2. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого
3. Байгаль орчны хууль эрхзүйн аудит
4. Цэвэрлэх байгууламж шинэчлэх төсөл хэрэгжүүлсэн
5. Цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулав
6. Мод тарих өдөрлөг
7. Нийгмийн хариуцлагын хүрээнд бэлчээрийн менежментийн зүй зохистой хэрэглээний талаар 119 малчдад сургалт зохион байгуулав

2019 оноос хойш үйл ажиллагаандаа байгаль орчны ISO14001 Стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлж ISO14001:2015 жил бүр тасралтгүй сайжруулан 2025 онд ОУ-ын баталгаажуулалын байгууллагаар аудитлагдаж батламж гэрчилгээ гардан авлаа.



Зураг.45 ISO14001 гэрчилгээ



Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого

2024 онд Говь ХК нь Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогоо баталсан нь компанийн байгаль орчны тогтвортой хөгжилд чиглэсэн томоохон алхам боллоо. Энэхүү бодлого нь дараах зорилтуудыг дэмжихэд чиглэгдэж байна:

- **Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах:** Үйлдвэрлэлийн бүх шатанд эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шинэ арга хэмжээг нэвтрүүлэх.
- **Байгалийн нөөцийг хэмнэх:** Ус, эрчим хүчний хэрэглээг оновчтой болгох, дахин ашиглах технологи нэвтрүүлэх замаар нөөцийн үр ашгийг дээшлүүлэх.
- **Тогтвортой үйлдвэрлэлийн шилжилт:** Байгаль орчинд ээлтэй технологи, түүхий эд ашиглах, үйлдвэрлэлийн сөрөг нөлөөг багасгах.
- **Нийгмийн оролцоог хангах:** Ажилтнууд болон орон нутгийн иргэдийг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл хэрэгт татан оролцуулах, сургалт, мэдээллээр хангах.

Бодлого батлагдсанаар Говь ХК нь байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах амлалт өгч байгаа бөгөөд энэ хүрээнд тодорхой арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн болно.

Байгаль орчны төлөвлөгөөт аудит

“Говь” ХК-ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл”-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийгдсэнээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянуулах, мэргэжлийн зөвлөгөө авах зорилгоор хамтран ажиллав. Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 798 асуулгын 536 (99.3%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 4 (0.7%) асуулгад сайжруулах шаардлагатай, харин 258 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна.

Байгаль орчны аудитын нийцлийн болон гүйцэтгэлийн 798 асуулга бүхий ажлын маягтуудыг нэгтгэсэн бөгөөд сайжруулах шаардлагатай арга хэмжээнүүд



1. Хуулийн нийцэл:


Үйлдвэрийн үйл ажиллагаанд хийгдсэн байгаль орчны төлөвлөгөөт аудитын дүгнэлт, аудитаар илэрсэн үл нийцлийг арилгасан тайланг Нийслэлийн Байгаль орчны газарт зөвлөмжид заасан хугацаанд жил бүр тогтмол хүргүүлэн тайлагнаж байх.

2. Усан орчны менежмент

Усны тухай хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Туул голын сав газрын захиргаагаар гаргуулан авч, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэх.

3. Аюултай хог хаягдлын менежмент

Хог хаягдлын тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 33.2-т заасан “Аюултай шингэн хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь асгарсан, алдагдсан хаягдал болон хуримтлагдсан хур тунадасыг тогтоон барих хязгаарлалтын системтэй байх” гэсэн шаардлагын дагуу аюултай шингэн хог хаягдал хадгалах талбайг тохижуулан, холбогдох хамгаалалтын системийг бүрэн суурилуулах.



Хүснэгт 13. Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэл

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ
Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам, стандарт шаардлагын дагуу бэлтгэсэн 798 асуулга бүхий ажлын маягтуудыг ашигласан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлсэн байдлын үнэлгээ (нийцэл /хангалттай/, тодорхойгүй /үнэлэх боломжгүй/, хугацаа болоогүй /ирээдүйд хийгдэх/, үл нийцэл /хангалтгүй/, хамааралгүй)-г нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо хамааралгүй гэсэн үзүүлэлтийг хасаж тооцсон болно.

№	Байгаль орчны аудитын хамрах хүрээ	Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын шалгуур үзүүлэлт					Хэсгийн дүн
		Нийцэл /хангалттай/ /Сайжруулах шаардлагатай/ /цаашид сайжруулах/	Хугацаа болоогүй /ирээдүйд хийгдэх/	Үл нийцэл /хангалтгүй/	Хамааралгүй		
1.	Хуулийн нийцэл	111	1	0	0	0	112
2.	Усан орчны менежмент	112	2	0	0	27	141
3.	Агаар орчны менежмент	18	0	0	0	28	46
4.	Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент	18	0	0	0	22	40
5.	Ургамлын нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент	13	0	0	0	29	42
6.	Хог хаягдлын менежмент						
6.1	- Ахуйн хог хаягдал	50	0	0	0	19	69
6.2	- Аюултай хог хаягдал	67	1	0	0	28	96
7.	Химийн хорт болон аюултай бодис	147	0	0	0	105	252
Нийт		536	4	-	-	258	798
Эзлэх хувь /%/		99.3	0.7	-	-	-	100

Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 798 асуулгын 536 (99.3%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 4 (0.7%) асуулгад сайжруулах шаардлагатай, харин 258 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна.

Хүснэгт 14. Байгаль орчны аудитын үл нийцлийн эрсдэлийн нэгтгэл

№	Байгаль орчны аудитын хамрах хүрээ	Үл нийцлийн эрсдэл				Хэсгийн дүн
		Их	Дунд	Бага	Үгүй	
1.	Хуулийн нийцэл	0	0	1	111	112

Зураг.46 Байгаль орчны аудитын тайлан



Технологийн хаягдлыг бууруулах, дахин боловсруулах арга хэмжээ

Ноорууран бүтээгдэхүүн нь Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүний нэг бөгөөд эдийн засагт чухал ач холбогдолтой. Гэвч ноолуурын үйлдвэрлэлийн явцад цувималын үлдэгдэл, хаягдал утас, цэвэр очёс зэрэг технологийн хаягдал үүсдэг нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор **Говь ХК** нь 2022 оноос эхлэн технологийн хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэн, хог хаягдлын хэмжээг бууруулахад чиглэсэн бодит үр дүнд хүрч байна.

1.Reborn коллекц Ноолууран утас үйлдвэрлэх процессын холих дамжлагаас гарсан хаягдал цувималуудыг нэгтгэн лабораторийн туршилтаар шинэ өнгө гарган, дахин давтагдашгүй загвар бүхий сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2024 онд Reborn коллекцын хүрээнд 13 төрлийн өнгөөр 27 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

2.Ноолууран хөнжил, мишок Ээрэх болон сүлжих дамжлагаас гарсан хаягдал утсыг дахин задлан зулхай болгон ашиглаж, ноолууран хөнжил, мишокны дүүргэлтэд хэрэглэснээр байгаль орчинд ээлтэй, дулаан хадгалах чадвар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

3.Дахин боловсруулсан ороолт Самнах дамжлагаас гарсан хаягдал цэвэр очёсыг дахин боловсруулж, өвөрмөц өнгө бүхий нэхмэл ороолт үйлдвэрлэж байна. 2025 онд нийт 140,078.453 кг технологийн хаягдал үүссэнээс 6,843.89 кг технологийн үлдэгдлийг дахин боловсруулж, нэхмэл болон сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

Байгаль орчны нөлөөллийг бууруулсан цайруулалтгүй технологи

Говь ХК нь байгаль орчны нөлөөллийг бууруулах, нөөцийн зохистой хэрэглээг дэмжих зорилгоор 2022 оноос эхлэн ноолуурыг цайруулахгүйгээр натурал өнгөн дээр шууд будах технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн.

- **Химийн бодисын хэрэглээ:** Цайруулах процессоос татгалзсанаар химийн бодисын хэрэглээ 6,809 кг-аар буурсан.
- **Усны хэрэглээ:** Натурал өнгөөр шууд будалт хийснээр 2,095 тонн ус хэмнэсэн.



- **Эрчим хүчний хэрэглээ:** Цайруулалтгүй технологи нэвтрүүлснээр 13 МВт.цаг эрчим хүчний хэрэглээ буурсан.

Эдгээр үзүүлэлт нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бодитоор бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлж буй үр дүнтэй арга хэмжээ юм.

Organic коллекц Ноолуурын байгалийн өнгийг шууд ашигласнаар:

- Химийн бодисын хэрэглээ **75%**
- Усны хэрэглээ **89%**
- Цахилгаан эрчим хүчний хэрэглээ **2%** тус тус буурсан.

Wholegarment / 3D коллекц Залгаасгүй технологиор үйлдвэрлэснээр:

- Үйлдвэрлэлийн хугацаа **36%**
- Цахилгаан эрчим хүчний хэрэглээ **12%** буурсан.

2025 онд:

- 277,216 ширхэг органик бүтээгдэхүүн
- 158,505 ширхэг Wholegarment/3D бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.
Хэрэв эдгээрийг уламжлалт 2D технологиор үйлдвэрлэсэн бол 22 тонн химийн бодис, 7,538 тонн ус, 359 МВт.цаг цахилгаан нэмэлтээр зарцуулагдах байв.

Говь ХК нь технологийн хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, байгалийн нөөцийн зохистой хэрэглээг хангах чиглэлээр бодит үр дүн бүхий арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Химийн бодис, ус, эрчим хүчний хэрэглээг бууруулсан тоон үзүүлэлтүүд нь байгаль орчны менежментийн тогтолцооны хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй байгааг харуулж байна.



3.9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны дээж шинжилгээг жил бүр тогтоосон цэгээс тогтмол авч хяналт тавин ажиллаж байна. Үйлдвэрийн орчмын хөрснөөс бохирдол их хогийн цэг орчим, химийн агуулахын, цэвэрлэх байгууламжийн лаг түр байршуулах талбай, гадаа талбайгаас хөрсний дээж шинжилгээг жилд 4 удаа авч БО-ны лабораторид хөрсний химийн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүн ЗДА хэвийн хэмжээндээ байна.

Агаарын найрлагыг жил бүр 5 цэгээс 2 удаагийн давтамжтайгаар Цаг уур орчны шинжилгээний газрын харъяа Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторит хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг хэмжүүлж жил бүр мониторинг хийн ажиллаж байна.



Зураг.47 Орчны хяналт шинжилгээ хийж байгаа байдал

Хөрсний задлан шинжилгээгээр төслийн талбайн хөрсөн дэх хүнд металлын агууламж хэвийн хэмжээнд байна.

Хотын ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлдэг бохир усыг БОХЗТ лабораторид шинжлүүлэхэд жинлэгдэх бодис, Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, нийт азот “Ариутгах татуургийн сүлжээнд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус”-ны стандарт шаардлага, түүнд тавих “MNS 6561:2015” стандартад нийцэж байна.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 6

№	Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт / /	160,949,611
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт / Нөхөн тарилт, хэлбэржүүлэлт, цэцэгийн мандал /	6,120,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт / Тэр бум мод арга хэмжээнд нэгдсэн /	10,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт / Химийн бодисын агуулахад химийн бодисын асгаралт мэдрэгч төхөөрөмж хяналт сайжруулалт устгал/	46,384,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт / Хатуу хог хаягдал, аюултай хог хаягдал /	52,259,952
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт /Аян, өдөрлөг, байгаль орчны сургалт, төсөл хөтөлбөр /	200,991,150 /Цэвэрлэх байгууламжийн 10% зардал, Байгаль орчны аудит, ёургалтын зардал/
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт /Агаар, Хөрс, цэвэр ус, бохир усны дээж шинжилгээ /	1,600,000
Нийт дүн		478,304,713



5. ДҮГНЭЛТ

Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Говь” ХК-ийн “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Тус төсөл нь байршил болон үйлдвэрлэлийн онцлогоос хамааран экологи, байгаль орчны бүрдэл хэсгүүд, хүн амын эрүүл ахуй, нийгэм, эдийн засагт үзүүлэх боломжит эерэг болон сөрөг нөлөөллийг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННУ) 2024 оны дүгнэлтээр тодорхойлсон. Уг үнэлгээний дагуу “Говь” ХК нь жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилладаг.

2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, хөтөлбөрүүд—сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгаль орчны чанарыг сайжруулах, нөөцийн хэмнэлт, аюулгүй ажиллагааг хангах зорилтууд—нь төлөвлөгөөт хугацаанд шат дараатайгаар бүрэн хэрэгжсэн бөгөөд үр дүнг энэ тайланд нэгтгэн хүргэж байна.



ХАВСРАЛТУУД

- Говь ХК-ны Улсын Бүртгэлийн Гэрчилгээ
- Газар эзэмших Гэрээ, гэрчилгээ
- Байгаль орчны аудит хийлгэсэн гэрээ
- Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ
- 2024 оны хаягдал усны дүгнэлт
- 2025 оны Ус ашиглуулах дүгнэлт
- Химийн агуулахын дүгнэлт
- Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ
- Химийн бодис, сав баглаа боодлын хаягдал шилжүүлэх, устгуулах гэрээ
- Аюултай хог хаягдал устгах, тээвэрлэх, гэрээ
- Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ
- Цэвэрлэх байгууламжийн гэрээ
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуух лабораторийн дүгнэлтүүд
- Галын дүгнэлт